

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОВХИМОЛ

2021 – 10 САР | ДУГААР 35

ГАРЧИГ

- 1–3** Бодлогын нийтлэл
- 4–6** Зохицуулалтын мэдээ
- 7–10** Байр суурь
- 11** ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ
- 12** УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ТҮҮНИЙ ӨРТӨГ
- 13–14** ФИНТЕКИЙН ТОП ТРЕНДҮҮД
- 15–19** Судлаачийн индэр
- 20–21** Цуврал хичээл
- 22** Хэрэглэгч
- 23** Компанийн засаглал
- 24–27** ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ
- 28** Өргөн дурал
- 29–30** Олон улсын зах зээлийн мэдээ
- 31** Олон улсын хөрөнгийн зээлийн индекс

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Манай улсын даатгалын салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний чанар хүртээмж жилээс жилд сайжирч байгаа хэдий ч иргэд, аж ахуй нэгжийн даатгалд хамрагдалтын түвшин олон улстай харьцуулахад, мөн даатгалын хураамжийн орлого бусад санхүүгийн салбарын орлогын Монгол Улсын ДНБ-д эзэлж буй хэмжээтэй харьцуулахад тус тус харьцангуй доогуур түвшинд байсаар байна. 2021 оны 3-р улирлын байдлаар салбарын тоон үзүүлэлтүүдээс дурдвал:

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ердийн даатгалын 15, урт хугацааны болон давхар даатгалын тус бүр нэг компани үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрийн 300 гаруй салбар, төлөөлөгчийн газар, мөн даатгалын мэргэжлийн оролцогч болох 2,388 гаруй даатгалын төлөөлөгч, 56 даатгалын зуучлагчаар дамжуулж Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 621 даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэж байна. 2021 оны 3-р улирлын байдлаар 25 даатгалын хохирол үнэлэгч даатгалын тохиолдлын хохирлыг үнэлж ажиллаж байна ;

Даатгалын компаниудын нийт хөрөнгө 444.6 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд сүүлийн өмнөх оны мөн үеэс 13.8 хувийн өсөлтийг үзүүлж байна. Хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл 40.8 тэрбум төгрөг буюу 9.2 хувийг мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, 234.0 тэрбум төгрөг буюу 52.6 хувийг хөрөнгө оруулалт, 32.4 тэрбум төгрөг буюу 7.3 хувийг үндсэн ба биет бус хөрөнгө /цэвэр дүн/, 30.9 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна ;

Даатгалын компаниуд 187.2 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 1.3 тэрбум төгрөгийн нийт 188.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлжээ. Ердийн даатгалын компаниудын хувьд 4.4 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийж, 74.9 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулж, 107.8 тэрбум төгрөгийн даатгалын цэвэр хураамжийн орлоготой ажиллажээ. “Үндэсний давхар даатгал” ХК 3.5 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамж төвлөрүүлж, үүнээс 1.8 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамж /retrocession/ хэлбэрээр гадны давхар даатгагчид шилжүүлсэн байна ;

2021 оны 3 дугаар улирлын байдлаар урт хугацааны болон ердийн даатгалын компаниуд нийт 44.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бөгөөд ердийн даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардлын 17% хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нөхөн төлбөр эзэлж байна ;

Даатгалын гүнзгийрэлт буюу дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх даатгалын хураамжийн орлогын хувь хэмжээ нь 0.52 хувь байгаа нь хөгжиж буй орнуудтай харьцуулахад 7.1 дахин бага байна ;

Даатгалын нягтрал буюу нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ нь 61,117 мянга байгаа нь хөгжиж буй орнуудын дундаж болох 207 ам.доллартай харьцуулахад 9.6 дахин бага байна.

Даатгалын зах зээлийн бүтэц дэх амьдралын даатгал нь дэлхийн дунджаар 55 хувь, хөгжиж буй орнуудад 54 хувийг эзэлж байгаа бол манай улсын хувьд 1 орчим хувийг эзэлж байна.

Даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хөгжил, үйл ажиллагааг зохистой явуулахын тулд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд цахим болон аливаа дэвшилтэд технологи ашиглаж даатгуулагч бүрд тохирох үйлчилгээг хүртээмжтэйгээр хүргэх, улмаар даатгагчийн хөрөнгийг олон талт хөрөнгө оруултад байршуулж, эрсдэлийг тархах, даатгагчийн хөрөнгө зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, даатгалын компанид зохистой засаглалын зарчим, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, даатгуулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо “Даатгалын багц дүрэм”-ийн холбогдох дараах дүрэм, журмуудыг Олон улсын туршлага, зарчим, зөвлөмж /даатгалын тулгуур зарчим /-д нийцүүлэн шинэчлэн ажилласан. Тухайлбал:

Үргэлжлэл 2-р нүүрт >>



ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА

Эзэмшигчид нь энгийн хувьцаа эзэмшигчдээс өмнө тодорхой тогтсон хэмжээгээр ногдол ашиг авах эрх эдэлдэг, мөн хязгаарлагдмал саналын эрхтэй, хувьцааны нэг төрөл.



PREFERRED STOCK

A class of shares of stock in a corporation which gives the holders priority in payment of dividends over owners of "common" stock at a fixed rate.

Эх сурвалж:

Банк санхүүгийн тайлбар толь бичиг

БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Эхлэл 2-р нүүрт >>

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн нэгдүгээр хавсралт “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын шинэчилсэн найруулгыг баталсан.

◆ Бүртгэл зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулахаар болов.

Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл авах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ өргөдөл гаргагчаас заавал цаасаар холбогдох бичиг баримтыг авч, хянадаг байсан бөгөөд энэ нь цаг үеийн чиг хандлага буюу технологид суурилсан үйл ажиллагааг ашиглагдаггүй байсан. Иймд уг журамд бүртгэл, зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулахтай холбогдох зохицуулалтыг тусгаж өгснөөр зохицуулалтын байгууллагууд буюу өргөдөл гаргагчдын цаг хугацааг хэмнэх, ажлын ачааллыг бууруулах, улмаар Монгол Улсад regtech зохицуулалтын эрх зүйн орчин бүрдэх үед даатгалын салбарын зохицуулалт бэлэн байх үр ашгийг бий болгосон. Тодруулбал өргөдөл гаргагч Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлэх 6, Хорооноос зөвшөөрөл авах 3 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах баримт бичгийг цахимаар ирүүлж болох бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагчид хянасны үндсэн дээр цахим хуудсанд бүртгэл, зөвшөөрлийн хүсэлттэй холбогдох мэдээллийг байршуулснаар уг үйл ажиллагаа хүчин төгөлдөр болох тухай заалтуудыг тусгаж өгсөн.

◆ Зарчимд суурилсан зохицуулалтыг бий болгов.


Санхүүгийн салбарын өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын бүтээгдэхүүнийг зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсны

үндсэн дээр зах зээлд борлуулдаг буюу зохицуулалтыг (prior approval) өөрчилж зарчимд суурилсан зохицуулалтыг (principle based) бий болгосон; Тодруулбал өмнөх зохицуулалтаар даатгалын компаниуд даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулахаас өмнө заавал Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулдаг байсан бол даатгагчийн ТУЗ нь өөрөө зах зээлд борлуулах бүтээгдэхүүнээ хянаж, дараа нь Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх ба уг бүтээгдэхүүн нь хэрэглэгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдол гарвал даатгагчийн ТУЗ-д хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгосон.

Ингэснээр даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар хүртээмж, салбарын өрсөлдөөн нэмэгдэх, улмаар ёс зүйтэй, хариуцлагатай ТУЗ-тэй даатгалын салбар бий болох давуу талтай юм.

◆ Технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, сайжруулах зохицуулалтыг бий болгов.

Санхүүгийн шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжих, зохицуулалтын орчинг сайжруулах зорилгын хүрээнд даатгагч, даатгалын зуучлагч нь даатгалын гэрээг цахимаар болон аливаа дэвшилтэд технологи ашиглан байгуулахад тавигдах шаардлагууд болон даатгагчийн ТУЗ-с баталж, хэрэгжүүлэх технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хөгжүүлэх бодлого, журамтай байх шаардлагуудыг бий болголоо; Тодруулбал өмнөх зохицуулалтаар даатгалын гэрээг цахимаар байгуулахад зөвхөн даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтүүд тусгагдсан байсныг олон улсын зарчимд нийцүүлэн сайжруулж, мөн даатгалын зуучлагчид цахимаар гэрээ байгуулахад тавигдах шаардлагыг нэмж тусгасан бөгөөд технологид суурилсан шинэ



бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хөгжүүлэх журамтай байхыг шаардлагыг тусгаснаар зах зээлд цахим даатгалын үйлчилгээнүүд бий болох боломжийг бүрдүүлсэн.

◆ **Даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулсан.**

Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь үйлчлүүлэгчтэй даатгалын гэрээг байгуулахаас өмнө болон гэрээ байгуулагдсаны дараа журамд заасан мэдээллүүдийг үйлчлүүлэгчид өгөх ба мэдээлэл өгснөө даатгагч, даатгалын зуучлагчид баримтжуулан ажиллах шаардлагыг тусгаж даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг сайжруулсан ;

Тодруулбал өмнөх зохицуулалтаар даатгалын гэрээ байгуулахад тавигдах шаардлагууд тусгагдсан байсан хэдий ч практикт иргэд, даатгуулагчид байгуулж буй даатгалын гэрээгээ уншиж, танилцдаггүй, хангалттай ойлголт авдаггүйн улмаас даатгагч, даатгуулагчийн дунд үл ойлголт үүсэх, даатгуулагчид хохирох үзэгдэл ихээр гардаг. Иймээс тус журамд даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогч нь даатгалын гэрээ байгуулахаас өмнө даатгуулагчид заавал өгсөн байх мэдээллийг тусгаж, уг мэдээллийг үйлчлүүлэгчид хүргэснээ баталгаажуулдаг байх ба гэрээ байгуулагдсаны дараа хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавигдах шаардлагуудыг тусгасан.

◆ **Компанийн засаглалыг сайжруулах зохицуулалтыг нэмж тусгав.**

Компанийн засаглалын сайн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор даатгагчийн үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөл /ТУЗ/-ийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлж, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хараат бус системийг бүрдүүлэх, сайжруулах зорилгын хүрээнд эрсдэлийн удирдлагын нэгж, үйлчлүүлэгчийн өргөдөл, гомдлыг барагдуулах эрх ашгийг хамгаалдаг нэгжтэй байх эсхүл тэдгээрийн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжүүдийг байгуулж, нэгжүүд нь өөр хоорондоо хараат бус хяналт тавих тогтолцоог бүрдүүлсэн байх зохицуулалтыг тусгасан; Тодруулбал журамд шинээр ТУЗ-ийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлбэл зохих дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг тусгаж, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрсдэлийн удирдлагын нэгжүүд нь өөр хоорондоо хараат бус тогтолцоог бүрдүүлэх шаардлагыг тусгасан.

◆ **Мэдээллийн ил тод байдлыг сайжруулав.**

Даатгагч нь өөрийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэх мэдээллүүдийг тодорхойлж, мөн Санхүүгийн зохицуулах хороо нь даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбогдох мэдээллийг өөрийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэх зохицуулалтыг тусган даатгалын зах зээлийн мэдээллийн ил тод байдлыг сайжруулсан; Тодруулбал даатгагчид нь өөрийн цахим хуудсандаа компанийн ерөнхий мэдээлэл, удирдлагын мэдээлэл, санхүүгийн мэдээлэл, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээлэл, даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл зэргийг дэлгэрэнгүй байршуулсан байх шаардлагыг тусгасан. Ингэснээр иргэд, үйлчлүүлэгчдэд даатгагчдын мэдээлэл ил тод болж зөв сонголт хийх боломж бүрдсэнээс гадна, даатгалын орлогын шимтгэлтэй холбогдох асуудлууд буурах юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 64 дүгээр тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн хоёр болон дөрөвдүгээр хавсралтад нэмэлт, өөрчлөлтийг баталсан.

Хөрөнгийн зах зээлд даатгалын салбарын оролцоо, мөн даатгалын салбарт хөрөнгийн зах зээлийн оролцоо чухал байдаг. Эдгээр зах зээл хөгжих тусам, хоорондын харилцан хамаарал нэмэгдэж байдаг. Даатгалын болон хөрөнгийн зах зээл нь нягт уялдаа холбоотойгоор хамтран ажиллаж, зэрэгцэн хөгжсөнөөр улс орны санхүүгийн зах зээлд томоохон зэрэг өөрчлөлт, нөлөөллийг авч ирдэг гэж хэлж болно. Даатгалын салбарын хувьд 4 компани олон нийтэд хувьцаагаа нээлттэй арилжаалж байна. Мөн даатгалын компаниуд нийт хөрөнгөөсөө Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн хувьцаа болон компанийн өрийн хэрэгсэлд байршуулж байдаг. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулж, даатгалын компаниудад “Компанийн өрийн хэрэгсэл” болон хувьцаа хэлбэрээр хөрөнгө оруулалтад 190 орчим тэрбум төгрөг хүртэл хөрөнгийг байршуулах боломжийг бүрдүүлсэн бөгөөд журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш даатгалын компаниуд хувьцаа болон бондод 12.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулсан байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор “Даатгалын багц дүрэм”-ийн арван гуравдугаар хавсралт “Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөөнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн найруулгыг баталсан.

Даатгагч давхар даатгалтай холбоотой үүсэж болох эрсдэлүүдийг олон талаас нь харгалзан тооцоолж, тэдгээрийг оновчтой байдлаар өөрөө удирдах арга хэрэгслийг тодорхойлдог байхаар “Даатгалын тулгуур зарчим”-д тусгагдсаны дагуу уг эрхзүйн актад даатгагч өөрийн эрсдэлийг зохистой байдлаар тодорхойлж, тэдгээрийг тохирох арга хэрэгслийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх зохицуулалтыг бий болгосон.

Санхүүгийн зохицуулах хорооноос дээрх журмуудыг шинэчилж ажилласнаас гадна амьдралын даатгалыг хөгжүүлэх, хариуцлагын даатгалын тогтолцоог бий болгох, технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, давхар даатгалын үйл ажиллагааг сайжруулах, мэргэжлийн хөрөнгө оруулагч даатгагчдыг бий болгох, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, даатгалын мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах, даатгалын зуучлалын үйл ажиллагааг сайжруулах зэргээр Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулиудыг шинэчлэхээр ажиллаж байна.

Мөн Даатгагчдын зохицуулалтын шаардлагууд, бизнесийн ёс зүйн үүднээс тогтвортой үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа тохиолдолд цаг үеэ олсон бөгөөд зөрчил, дутагдалд тохирсон урьдчилан сэргийлэх, засаж залруулах арга хэмжээ авч чаддаг байх шаардлагатай тул даатгалын салбарын эрсдэлийн удирдлагыг сайжруулах, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулахаар ажиллаж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

САНАМЖ БИЧИГ ҮЗЭГЛЭЛЭЭ



Санхүүгийн зохицуулах хороо хүртээмжтэй, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлт, хөгжлийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлсээр байна. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо Санхүү эдийн засгийн их сургууль /СЭЗИС/-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа.

Санамж бичгийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, СЭЗИС-ын ректор Б.Мөнхбаяр нар үзэглэж зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бодлого зохицуулалтын оновчтой зөв шийдвэр гаргахад түлхэц болсон хамтарсан судалгаа, шинжилгээ хийх цаашилбал гадаад, дотоодын төсөл хөтөлбөр болон салбарын хөрөнгө оруулалтад шаардлагатай зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллахаар тохиролцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр “Санхүүгийн зах зээлд технологийн дэвшил гүнзгий нэвтэрч байгаатай холбоотойгоор зах зээлийн эрсдэлийн түвшин, хүчин зүйл, эрсдэл даах чадвар, мэдрэмтгий байдлыг тооцоолох шинжилгээг хамтран хийж, үнэлгээний оновчтой аргачлалыг боловсруулахад туршлага солилцох, бичил санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлд үзүүлэх макро түвшний хүчин зүйлс болон бусад судалгаа, шинжилгээг хийх, зах зээлийн хөгжлийн ирээдүйн чиг хандлагын талаар таамаглал дэвшүүлэх загварчлалыг хамтран гаргахаар зорьж байна. Бидний хамтын ажиллагаа үр өгөөжтэй байх болтугай” гэсэн юм. Харин СЭЗИС-ын ректор Б.Мөнхбаяр “СЭЗИС-ын зүгээс Санхүүгийн



зохицуулах хороотой хамтран ажиллах болсондоо талархаж байна. Бидний хувьд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын салбар болон шинэ технологи, финтек, комплайнс, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх мөн бусад судалгаа, шинжилгээний чиглэлээр хамтран ажиллах, судалгаандаа ахисан түвшний оюутнуудыг оролцуулах болно” гэдгийг онцолсон юм.

“НОГООН БОНД ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА” ВЕБИНАР БОЛНО

Ногоон бонд гаргах үйл ажиллагаа
Webinar on Green Bond Issuance

Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төсөл

2021 оны 10 сарын 21
16:00 - 18:00

- Компаний өрийн хэрэгслийг бүртгэх журам: Ногоон бондыг бүртгэх зохицуулалтууд - **Санхүүгийн Зохицуулах Хороо**
- Ногоон бонд гаргах үйл ажиллагаа: Гол хийгдэх ажилууд, үнэ тогтоох, хөрөнгө оруулагчдын тавьдаг гол шаардлагууд - **Олон Улсын Санхүүгийн Корпораци**

Бүртгэл:
sbold@ifc.org
Дээрх хааг луу нэр, холбоо барих утасны дугаарын хамт явуулна уу.

The project is implemented in partnership with the Government of Japan.

Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын тогтвортой санхүүгийн холбоо, Олон улсын санхүүгийн корпорациас хамтран зохион байгуулж буй “Ногоон бонд гаргах үйл ажиллагаа” вебинар 10 дугаар сарын 21-ний өдөр амжилттай зохион байгуулагдлаа.

Вебинараар Компанийн өрийн хэрэгслийг бүртгэх журам: Ногоон бондыг бүртгэх зохицуулалтууд, Ногоон бонд гаргах үйл ажиллагаа: Гол хийгдэх ажилууд, үнэ тогтоох, хөрөнгө оруулагчдын тавьдаг гол шаардлагуудын талаар танилцуулга хийлээ.

СЭНДБОКСЫН ЗӨВЛӨЛИЙН АНХНЫ ХУРАЛДААН БОЛЛОО

Сэндбокс зохицуулалтын орчны журам, Сэндбоксын зөвлөлийн дүрэмд заасны дагуу Сэндбоксын зөвлөл байгуулагдаж анхны хуралдаан



Санхүүгийн зохицуулах хорооны хурлын танхимд боллоо.

Уг хуралдаанаар зөвлөлийн гишүүдэд Сэндбокс зохицуулалтын орчны журам, олон улс дахь сэндбокс зохицуулалтын орчны талаар товч

танилцуулж мэдээлэл өгөхийн зэрэгцээ Сэндбоксын зөвлөлийн дүрэм, ажлын хэсгийн удирдамжийн талаар танилцуулсан юм.

Сэндбоксын зөвлөлийн зөвлөлийн даргаар Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга Н.Хүдэрчулуун сонгогдон ажиллаж байгаа бол зөвлөлийн гишүүдээр Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, МУИС-ын Бизнесийн сургуулийн захирал Ч.Энхбаяр, Монголын программ хангамж үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч Ц.Чулуунзагд, Улаанбаатар хотын Худалдааны танхимын дэргэдэх Монголын финтек, блокчэйны зөвлөлийн гишүүн, “Ард экс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Ганзориг нар ажиллаж байна.

ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ




Виртуал хөрөнгө нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд хамрагдах хувьцаа, үнэт цаас, төгрөгтэй адил үнэ цэнэ бүхий, мөнгөн хөрөнгөөр

баталгаажуулах, Монголбанкны зөвшөөрөлтэй төлбөрийн хэрэгслийн шинжийг агуулаагүй, компанийн хөрөнгө, хувьцаа хэлбэрээр баталгаажих боломжгүй тул ирээдүйд учирч болзошгүй эрсдэл, хохирлыг төр аливаа хэлбэрээр хариуцахгүй болохыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос албан ёсны хуудсаар дамжуулан мэдэгдэл гаргав.

Учир нь иргэдийн койн худалдан авах замаар богино хугацаанд өндөр ашиг олох сонирхол нь өндөр эрсдэлийг дагуулж болзошгүй юм.

Түүнчлэн Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1 дэх хэсгийн бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо зарлан сурталчлахыг хориглодог.

Д.БАЯРСАЙХАН:ШИЛДЭГ АЖ АХУЙН НЭГЖҮҮД ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРАХАД ХЯЛБАР, ШУУРХАЙ БОЛСОН



Санхүүгийн зохицуулах хороо хүртээмжтэй, олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бүрдүүлэх, эдийн засгийн өсөлт, хөгжлийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлсээр байна. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах

хорооны дарга Д.Баярсайхан санхүү, хөрөнгийн зах зээлийг үе шаттайгаар хөгжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бизнесийн таатай орчин бүрдүүлэх чиглэлд хамтран ажиллах тухай Монголын үндэсний



худалдаа аж үйлдвэрийн танхим /МУХАҮТ/-ын ерөнхийлөгч О.Амартүвшинтэй уулзаж санал солилцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан энэ үеэр “Хороо Үнэт цаасны бүртгэлийн журмаа олон улсын жишигт нийцүүлж хувьцаа болон компанийн бонд гэж бүтээгдэхүүний төрлөөр нь хоёр журам болгон ангилсан. Үүний нэг болох “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-аар Засгийн газар, МУХАҮТ-аас хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарсан компанийн олон нийтэд санал болгон гаргаж буй бондыг хялбаршуулсан байдлаар Санхүүгийн зохицуулах хороо бүртгэхээр болсон бөгөөд бонд гаргагч компани нь “Бонд гаргах хөтөлбөр” хэрэгжүүлэх замаар нэг удаа бүртгүүлсэн бондоо бүхэлд нь эсвэл хэсэгчлэн олон нийтэд санал болгож санхүүжилт татах давуу талыг бүрдүүлсэн. Ингэснээр дотоодын шилдэг аж ахуйн нэгжүүд банкны өртөг өндөр зээлтэй харьцуулахад урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэрийг хөрөнгийн зах зээл дээрээс хялбар, түргэн шуурхай байдлаар татан төвлөрүүлж үйл ажиллагаандаа зарцуулах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж бий болж цаашлаад дотоодын бондын зах зээлийн хөгжил олон улсын түвшинд хүрэхэд нөлөөлөхүйц бодлогын чухал алхам боллоо. Мөн Инновацийн тухай хуульд заасны дагуу гарааны компани биржийн бус зах зээл дээр хувьцаагаа олон нийтэд гаргахтай холбоотой нэмэлт зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хорооны “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-даа тусгаж оруулсан. Ингэснээр гарааны компаниуд биржийн бус зах зээлээр дамжуулан төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтаа үе шаттайгаар мэргэжлийн хөрөнгө оруулагчид, өндөр орлоготой эрсдэл даах чадвартай иргэдээс татан төвлөрүүлэх эрх зүйн зохицуулалтын орчинг анх удаа амжилттай бүрдүүлж чадсан” гэдгийг онцолсон юм.

ДЭЛХИЙН БАНКТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Дэлхийн банкны Монгол Улсын санхүүгийн салбарын асуудал хариуцсан ахлах шинжээч Тиласони Бенжамин Мусукуг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан “Дэлхийн банк нь Монгол Улсын эдийн засгийг сэргээхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг, техникийн туслалцаа үзүүлж ирсэн бөгөөд хамтын ажиллагааны 30 жилийн түүхэнд Монгол орны хөгжлийн гол түнш байсаар ирсэн. Дэлхийн банкнаас олгосон дэмжлэгүүд салбарын өсөлтийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангахад түлхэц болсон. Тухайлбал, банкны санхүүжилтээр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк хамтран Монгол Улсын төсвийн орлогыг үр ашигтай удирдах чадавхыг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор “Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл”-ийг 2014–2017 онд амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд үүний үргэлжлэл “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийг одоо хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд санхүүгийн зах зээлийн хууль эрх зүй, зохицуулалтын орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж олон үр дүнд хүрсэн” гэдгийг онцолсон юм.

Хоёр тал энэ үеэр одоо хэрэгжиж байгаа зарим төслийн хэрэгжилт, үр дүн болон цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Тухайлбал, төслийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны эрхзүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, даатгалын багц хуулийн төсөл, Хамтын санхүүжилтийн тухай хуулийн төслийг боловсруулж санхүүгийн салбарын хууль эрхзүйн орчныг сайжруулах цогц ажлыг хэрэгжүүлж байна. Мөн салбарын хэмжээнд мөнгө угаах, терроризмын санхүүжилтийн эрсдэлийн үнэлгээг анх удаа хийлээ.

Цаашид санхүүгийн салбарт ногоон санхүүжилтийн бодлого хэрэгжүүлэх, крипто валютын зохицуулалтын орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, тэр дундаа байгууллагын хэлбэрийн хөрөнгө оруулагчдыг хөгжүүлэх чиглэлээр суурь судалгаа хийх, судалгаандаа тулгуурласан хөгжлийн стратегийн зөвлөмж боловсруулах чиглэлээр хамтран ажиллах тухай санал солилцлоо.

ДААТГАЛЫН 608 БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ШИНЭЧЛЭН БҮРТГЭЛЭЭ

Санхүүгийн салбар түүн дотроо даатгалын салбар дахь өрсөлдөөнийг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор энэ онд Санхүүгийн зохицуулах хорооноос “Даатгалын багц дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулсан. Даатгалын компаниуд бүтээгдэхүүнээ зохицуулагч байгууллагад хянуулж, бүртгүүлсний үндсэн дээр зах зээлд борлуулдаг байсныг өөрчилж даатгалын компанийн эрх бүхий албан



тушаалтан даатгалын бүтээгдэхүүнээ хянаж, батлаад Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэнэ. Үүний дараа Санхүүгийн зохицуулах хороо цахим хуудсандаа байршуулснаар бүртгэсэнд тооцож тухайн

бүтээгдэхүүнээс үүдэж даатгуулагчийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээх тогтолцоог бүрдүүлсэн. Ингэснээр даатгагчид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд түргэн шуурхай нэвтрүүлэх, даатгалын бүтээгдэхүүний чанар, хүртээмж, тоо хэмжээ нэмэгдэх, технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжих нөхцөл бүрдлээ.

Нөгөөтэйгүүр Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулсан даатгалын бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээллийг даатгалын компани цахим хуудсандаа байршуулах ба ингэснээр иргэд, аж ахуй нэгжүүд даатгалын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээнд харьцуулалт хийсний үндсэн дээр зөв сонголт хийх боломж нээгдэж байна.

Дээрх зохицуулалтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо даатгалын 50 бүтээгдэхүүнийг шинээр, 571 бүтээгдэхүүнийг (давхардсан байдлаар) шинэчлэн бүртгэж цахим хуудсандаа байршуулаад байна. Тодруулбал Монгол Улсын даатгалын зах зээл дээр даатгалын 22 хэлбэрт хамаарах 621 бүтээгдэхүүн борлуулагдаж байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНД НЭГДЭЖ НЭРЭМЖИТ ТӨГӨЛТЭЙ БОЛЛО



Өнөөдрийн байдлаар Монгол Улсын нийт газар нутгийн 76.9 хувь нь буюу 120 сая га талбай цөлжилтөд өртөж, газрын доройтолд орсон судалгаа бий.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх байгаль орчны доройтол, цөлжилт, шар шороон шуургатай тэмцэх зорилгоор Монгол Улс 2030 он гэхэд тэрбум мод тарьж ургуулахаар төлөвлөснөө НҮБ-ын Ерөнхий ассамблейн 76 дугаар чуулганд оролцохдоо зарлаад “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан эхлүүлээд байна.

Санхүүгийн зохицуулах хороо зохицуулалтын байгууллагуудынхаа хамт эх байгалиа хайрлан хамгаалж, мод тарьж ургуулах үйлсэд хувь нэмрээ



оруулахаар үндэсний хөдөлгөөнд нэгдэж Сонгинохайрхан дүүргийн Баруун салаа дахь Бумбатын булагт мод тарьж нэрэмжит төгөлтэй боллоо.

Санхүүгийн зохицуулах

хорооны дарга Д.Баярсайхан арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Байгаль хамгаална гэдэг бол оршин тогтнох, амьд явах, эрүүл байх орчноо хамгаалж байна гэсэн үг. Иймээс Санхүүгийн зохицуулах хорооны хамт олон бүгд нэг сэтгэлээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдсэн.

Санхүүгийн салбарынхны хувьд ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх нь санхүүгийн зах зээл болон хөрөнгө оруулалтын орчныг тэлэх боломжийн зэрэгцээ байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх бас нэгэн зорилтыг давхар агуулдаг тул Хорооноос ногоон санхүүжилтийг дэмжих судалгаа хийх, зохицуулалтын орчин бүрдүүлэх, тогтвортой ногоон санхүүжилтийг төлөвшүүлэх зорилтыг тусган ажиллаж, бодлого тодорхойлогчийн хувьд ногоон санхүүжилтийг дэмжих арга замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад онцгой анхааран ажиллаж байна. Иймд салбарын оролцогчдоо ногоон санхүүжилтийг хөгжүүлэх чиглэлд хамтран ажиллахыг уриалж байна” гэдгийг онцолсон юм.

БАЙР СУУРЬ

Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболдтой цөөн хором ярилцлаа.

Монгол Улсын даатгалын салбарын хөгжил ямар түвшинд байна вэ? Даатгалын салбарт үйлчилгээ үзүүлэгч хэчнээн даатгалын компани ямар төрлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна вэ?

Олон улсад даатгалын зах зээлийн хөгжлийг 4 үе шатад хувааж үздэг бөгөөд манай улсын даатгалын зах зээлийн хөгжил нь хөгжлийн эхэн үе буюу 2 дугаар үе шатад хамаарч байна. Сүүлийн 5 жилийн байдлаар даатгагчийн хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 19.1 хувиар, хураамжийн хэмжээ 11.3 хувиар өсөж, даатгалын зах зээл эрчимтэй хөгжин, малчин ард иргэдийг ган зудын аюулаас хамгаалах, зам тээврийн ослын хохирлыг бууруулах, ипотекийн зээлдэгчдийг эрсдэлээс хамгаалах зэргээр тус салбарын нийт эдийн засагт эзлэх хувь хэмжээ, гүйцэтгэх үүрэг, ач холбогдол жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байна. Гэсэн хэдий ч манай улсын даатгалын гүнзгийрэлтийн түвшин буюу даатгалын хураамжийн орлогын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 0.52, даатгалын нягтрал буюу нэг хүн амд ногдох даатгалын хураамжийн орлогын дүн ойролцоогоор 21.44 ам.доллартай /61,117 төг/ тэнцүү байгаа нь Хөгжиж буй улс орнуудын дунджаас тус тус 6 болон 8 дахин бага байна. Нөгөө талаас мөн энэхүү хэмжээний өргөжих зах зээлийн багтаамж байна гэж харж болно.

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ердийн даатгалын 15, урт хугацааны болон давхар даатгалын тус бүр нэг компани үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрийн 300 гаруй салбар, төлөөлөгчийн газар, мөн даатгалын мэргэжлийн оролцогч болох 2,388 гаруй даатгалын төлөөлөгч, 56 даатгалын зуучлагчаар дамжуулж 621 гаруй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэж ажиллаж байна.

Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ гэж юу вэ, энэхүү бүтээгдэхүүн, үйлчилгээнд хэрхэн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлдэг вэ ?

Даатгал нь нэгт хувь хүн, аж ахуй нэгж байгууллагад учирч болзошгүй эрсдэлийн улмаас үүсэх санхүүгийн хохирлоос хамгаалах, нөөц сан бүрдүүлэх буюу эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, хоёрт нөөц санг өсгөн арвижуулах, нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл даатгал нь нөөц сан бүрдүүлж, энэхүү сангаасаа хохирол учирсан нэгнийг санхүүгийн эрсдэлээс хамгаалдаг буюу бага зардлаар их хэмжээний санхүүгийн хохирлоо барагдуулах боломжийг олгодог эрсдэлийг шилжүүлэх арга хэрэгслийн хамгийн түгээмэл шийдэл юм. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийн улмаас үүсэх хохирлыг актуар тооцооллын үндсэн дээр тооцсон даатгалын хураамжийг даатгуулагчдаас төвлөрүүлж, даатгалын нөөцийн сан бүрдүүлэх, хохирол учрахад даатгуулагчдад нөхөн төлбөр олгох, даатгалын нөөц санг хөрөнгө оруулалтад байршуулах зэрэг мэргэжлийн үйл ажиллагааг даатгалын үйлчилгээ гэж хэлж болно.

Даатгалын тухай хуульд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгохоор тусгагдсан байдаг бөгөөд Даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбогдох зохицуулалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын багц дүрэм”-ээр зохицуулдаг. Одоогийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй 621 даатгалын бүтээгдэхүүн зах зээлд борлуулагдаж байна.

Даатгалын компани даатгалын бүтээгдэхүүний даатгалын хураамжийн хэмжээ, даатгалын гэрээ зэргийг Хороонд хянуулсны үндсэн дээр зах зээлд борлуулдаг байсан зохицуулалтыг 2021 оноос өөрчилж, зах зээлд борлуулах бүтээгдэхүүнээ компани өөрөө хянаж, Хороонд мэдэгдсэний үндсэн дээр борлуулах боломжтой байдлаар зохицуулалтыг шинэчилсэн. Өөрөөр хэлбэл даатгалын бүтээгдэхүүний зохицуулалт илүү хялбаршуулж цахим бүртгэлийн системд шилжээд байна.

Ингэснээр даатгалын компаниуд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ зах зээлд түргэн шуурхай нэвтрүүлэх, даатгалын бүтээгдэхүүний чанар, хүртээмж, тоо хэмжээ нэмэгдэх, технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ хөгжих нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн түүнчлэн иргэд, аж ахуйн нэгжүүд даатгалын компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээнд харьцуулалт хийсний үндсэн дээр хэрэгцээ шаардлагадаа нийцсэн зөв сонголт хийх боломжтой болсон.

Олон нийтийн дунд даатгалын хураамжийг татвар мэт ойлгодог. Та даатгалын бүтээгдэхүүний даатгалын хураамжийг хэрхэн тооцдог талаар мэргэжилтний хувьд тайлбарлаж өгөхгүй юу?

Даатгалын хураамжийн хэмжээг тухайн чиглэлээр мэргэшсэн буюу актуарчид эрсдэлийн төрөл, хэлбэрээс хамааран их тоон өгөгдөл дээр үндэслэн тооцдог.

Даатгалын хураамж нь даатгалын нөхөн төлбөр олгоход зориулагдсан даатгалын цэвэр хураамж болон даатгагч даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардал, ашгийг багтаасан байх бөгөөд даатгалын хураамжийн хэмжээ нь даатгагч, даатгуулагчийн эрх ашигт нийцэх, тогтвортой байх, даатгалын нөхөн төлбөр төлөхөд хүрэлцээтэй, үйл ажиллагааны зардлыг бүрэн нөхөхүйц байх, даатгалын бүтээгдэхүүний гэрээний нөхцөлтэй уялдсан байх зарчимтай.

Даатгалын компани нь даатгалын гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын нөөц санг бүрдүүлдэг бөгөөд жишээ нь ердийн даатгалын компанийн хувьд “учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан” (incurred but not reported– IBNR), “мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан” (reported but not paid–RBNP),

“учирч болзошгүй хохирлын нөөц сан” (unexpired risk reserve–URR), “тусгай нөөц сан”, “орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан” гэсэн “даатгалын нөөц сан”-гуудыг бүрдүүлэн ажиллахаар холбогдох журамд тусгагдсан байдаг.

Өөрөөр хэлбэл даатгалын үйл ажиллагаа нь бусад худалдаа, үйлчилгээний байгууллагаас ялгаатай бөгөөд даатгалын компани тухайн улирал, жилийн хураамжийн орлогоо бүгдийг нь орлогод тооцож авахгүй, харин хураамжийн орлогын зарим хэсгээр дээр дурдсан нөөц сангуудыг заавал бүрдүүлдэг бол зарим хэсгийг даатгалын нөхөн төлбөр, мөн зарим хэсгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж ажилладаг онцлогтой.

Та даатгалын үйл ажиллагаа нь бусад худалдаа, үйлчилгээний байгууллагаас ялгаатай гэж хэллээ. Тэгвэл даатгалын үйл ажиллагааны ашигт байдлыг хэрхэн тооцдог вэ?

Энэ оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын компаниуд нь 187.2 тэрбум төгрөгийн хураамжийн орлогыг төвлөрүүлж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас 17.0 тэрбум төгрөгийн өгөөжтэй ажилласан байх бөгөөд нийт хураамжийн орлогын 33% хувийг давхар даатгалын хураамжид шилжүүлж, 25% хувийг нөхөн төлбөрт зарцуулсан бол үлдэх хувийг даатгалын нөөц сан байгуулахад, даатгалын борлуулалт хийхтэй холбоотой үйл ажиллагааны зардал зарцуулж ажилласан байна.

Даатгалын үйл ажиллагааны ашигт байдлыг хохирлын харьцаа (loss ratio), зардлын харьцаа (expense ratio) болон хосолсон харьцаа (combined ratio) –аар илэрхийлдэг ба 2021 оны 3 дугаар улирлын байдлаар ердийн даатгалын компаниудын хувьд хосолсон харьцаа нь 108.5% хувь байна.



Энэ нь даатгалын компаниуд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас ашигтай ажиллаж байна гэсэн үг юм.

Санхүүгийн зохицуулах хороо цахим хуудсанд цаг тухай бүрд нь даатгалын салбарын улирал, жил бүрийн үйл ажиллагааны тайлан мэдээллийг байршуулдаг. Иймээс энэ талаарх холбогдох мэдээлэлтэй танилцах бүрэн боломжтой.

Зохицуулагч байгууллагын зүгээс даатгалын салбарт цаашид ямар үйл ажиллагаа хийвэл, илүү өргөжнө гэж харж байна вэ ?

Санхүүгийн үйл ажиллагаа нь итгэлцэл дээр тогтдог, тэр дундаа даатгалын үйл ажиллагааг илүү ёс зүйтэй, зарчимд суурилан явуулах нь зүйтэй бөгөөд даатгуулагчдын итгэлийг дааж, түүнийг хэвийн зохистой явуулснаар нийгэмд асар их дэмжлэг үзүүлдэг. Тухайлбал, улс орон, хүний амьдралын алхам тутамд аливаа эрсдэлд өртөх магадлал байсаар байдаг. Энэхүү үүсэж болзошгүй эрсдэлийг бусдад бага зардлаар шилжүүлснээр ирээдүйд гарах эдийн засаг, санхүүгийн хохирлоос хамгаалагддаг, нөгөөтээгүүр даатгалын компаниуд эрсдэлийг өөрт шилжүүлэн авсны төлбөрт бүрдүүлсэн хураамжийн орлогоор нөөц сан бүрдүүлэн, түүгээр бусад салбаруудад хөрөнгө оруулалт хийснээр нийгэмд зөв мөнгөн урсгал, тогтолцоо бий болдог.

Иймд арилжааны даатгалын салбарын зохицуулагч байгууллагын хувьд Санхүүгийн зохицуулах хороо нь тус салбарын мэргэшсэн байдал, компанийн засаглал, технологид суурилсан олон нийтэд хүртээмжтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалсан зохицуулалтуудыг сайжруулах зорилгоор Засгийн газар, Улсын Их Хурлаас баталсан бодлогын арга хэмжээнүүд болон Олон улсын зарчим зөвлөмжид нийцүүлэн салбарт тулгамдаж буй асуудлуудыг судлан, тус Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан Даатгалын багц дүрмийн “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор шинэчлэн найруулсан болно. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 114 дүгээр тогтоолоор “Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг баталсан бөгөөд энэ хүрээнд даатгалын зах зээлд оролцогч бүр ёс зүйн дүрэмтэй болж, мөрдөн хэвших, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэн, даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагаа илүү ёс зүйтэй, шударга өрсөлдөөнтэй явагдах, даатгуулагч олон нийтийн даатгалд итгэх итгэл нэмэгдэн даатгалын хамрагдалт өсөх зэрэг ач холбогдолтой юм.

Даатгалын зах зээл хөгжихийн хэрээр салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэх, сайжруулах цаг үетэй нь нийцүүлэх шаардлага үүсэж байна. 2018 оноос салбарын тулгуур хуулиуд болох Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуулийг шинэчлэхээр Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагууд хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаа бөгөөд тус ажлыг эрчимжүүлэхээр Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 112 дугаар тушаалаар даатгалын салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох буюу Даатгалын багц хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Энэ хүрээнд цахим болон аливаа дэвшилтэд технологийг / insurtech/ ашиглахыг дэмжсэн эрх зүйн орчин бүрдүүлэх, хариуцлагын даатгалын тогтолцоог сайжруулах, амьдралын даатгалыг хөгжүүлэх, салбарын мэргэжлийн дэд бүтцийн байгууллагыг бий болгох, давхар даатгалын үйл ажиллагааг сайжруулах, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох зэрэг тэргүүн зорилтуудыг тавьж, хуулиудыг шинэчлэхээр ажиллаж байна. Үүнээс онцолбол insurtech буюу дэвшилтэд технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлснээр даатгалын салбар өргөжих гол хөшүүрэг болно гэж харж байгаа.

Олон улсын санхүү, даатгалын салбарт технологийн дэвшлийг ашигласан бүтээгдэхүүн, үйлчилгээ ихээр нэмэгдэж, үүнийг дагаад технологийн салбарт оруулах хөрөнгө оруулалт тогтмол өсөж байна. Даатгалын гэрээ байгуулах, даатгалын тохиолдлыг баталгаажуулахад технологийн дэвшлийг ашигласнаар хэрэглэгч, даатгуулагчдад салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээ илүү хялбар, ойр болох, зардал хэмнэх, улмаар эдгээр үйлчилгээнээс гарах мэдээллүүдийг төвлөрүүлэх, хуваарилах, ашиглах зохицуулалт бүхий мэдээллийн нэгдсэн сан бий болж, технологижсноор эрсдэлийг илүү нарийвчлан үнэлэх боломж бүрдэх ба хамгийн гол нь даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ түргэн шуурхай, хүртээмжтэйгээр иргэн, аж ахуй нэгжид хүрэх болно.

Мөн дэлхий дахинд тархаад буй Коронавируст цар тахлаас олон нийтийг хамгаалахын тулд санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах, технологижуулах зайлшгүй шаардлага бий болоод байна.

Цар тахал Ковид-19 манай улсын даатгалын салбарт хэрхэн нөлөөлсөн бэ? Үүсэж болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээнүүдийг тус Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс хэрэгжүүлж ажилласан бэ?

Цар тахал тус салбарт хэрхэн нөлөөлснийг 2021 оны 2 улирлын тайланг 2020 оны мөн үе буюу Ковид-19 цар тахал дотоодод дэгдэхээс өмнөх үеийн тайлантай харьцуулж, товч дүгнэн үзэхэд, санхүү, итгэлцэл, зээл, хариуцлагын даатгал зэрэг даатгуулагчийн бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдсантай холбогдох даатгалын бүтээгдэхүүнүүд болон гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгалтай холбогдох нөхөн төлбөрийн хэмжээ даатгагчийн тооцоолсноос давж, жолоочийн хариуцлагын даатгал болон авто тээврийн хэрэгслийн даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ 12.1%-иар буурсан нь Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хорио цээрийн арга хэмжээний улмаас даатгалын тохиолдлын тоо буурсантай холбоотой байна. Харин компаниудын төлбөрийн чадвар, нөөц сан, хөрөнгөд төдийлөн сөрөг нөлөө үзүүлээгүй байна.

Ковид-19 цар тахал, улсын хэмжээнд хөл хорио тогтоосонтой холбогдуулан 2020 оны 2 дугаар сард тус Санхүүгийн зохицуулах хорооноос нөхцөл байдлыг судалж, гадаадад зорчигчдын гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгал, нийтийн зорчигч тээврийн даатгал, гадаад, дотоод ачаа тээврийн даатгалын бүтээгдэхүүний борлуулалт зогсох, иргэд, аж ахуй нэгжийн санхүүгийн чадамж буурснаар даатгалын хураамж төлөлт тасалдах, даатгалын нөхөн төлбөрийн зардал нэмэгдэх, компаниуд ажилтнуудаа халдвараас хамгаалж зайнаас ажиллуулах, ажлын цагийг багасгах зэргээс хамаарч даатгалын хураамжийн орлого буурах, үйл ажиллагааны тогтвортой байдал алдагдах гэх мэт олон сөрөг нөхцөл байдлууд үүсэж болзошгүй гэж таамаглаж байлаа.

Иймд дээрх таамаглалыг харгалзан үзэж тус Санхүүгийн зохицуулах хороо нь 2020 оны 2 дугаар сарын 29-ний өдрөөс Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, Төлбөрийн чадвар, хөрөнгийн чадавхийн эрсдэлийг бууруулах, Даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах гэсэн үндсэн 3 чиглэлээр холбоодтой хамтран даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх олгох сургалт, шалгалт семинар зэргийг онлайн хэлбэрт шилжүүлж ажиллах, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэл, зөвшөөрлийн цахим системийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, цахим дэвшилтэт технологи ашиглалт, цар тахалтай холбогдох шинэ бүтээгдэхүүний үйлчилгээ нэвтрүүлэхийг дэмжих зэрэг 8 арга хэмжээг бодлого, зохицуулалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн.

Энэ хугацаанд даатгалын компанийн санхүүгийн тайлагнал, төлбөрийн чадварын үзүүлэлтүүдэд стресс тест, эрт


анхааруулах шинжилгээг ашиглан тогтмол хяналт тавьж, олон нийтийн даатгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх 2 теле, 1 аудио хичээл, гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгалын талаарх мэдээллийг түгээж, Санхүүгийн зохицуулах хорооны бүртгэл зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах, хялбарчлах болон даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, цахим даатгал, компанийн засаглалыг сайжруулах зорилгоор дээр дурдсанчлан Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 25 дугаар тогтоолоор “даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийг шинэчлэн найруулсан. Цар тахалтай холбогдох хэд хэдэн даатгалын бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрсэн юм.

Тухайлбал, “Нэйшнл лайф даатгал” ХХК-аас нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэ оны дөрөвдүгээр сарын 8-ны өдөр 9 дүгээр сар хүртэл хэрэгжих “Ковид-19 амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал”-ын бүтээгдэхүүнийг Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлж цар тахлын халдварын эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй 1,587 төрийн тусгай албан хаагчийг үнэ төлбөргүй даатгалд хамруулсан. Мөн тус компаниас иргэд, даатгуулагчид шинэ Коронавирусын улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдах боломжийг бий болгож буй “Ковид-19” эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг боловсруулж ирүүлснийг Санхүүгийн зохицуулах хороо цахимаар хянаж, 11 дүгээр сарын 24-ний өдөр бүртгэлээ.

Мөн түүнчлэн “Мандал Даатгал” ХК нь 2020 оны 5-р сард Ковид хүртээмжтэй даатгалыг бүртгүүлэн өөрийн харилцагч 82,000 даатгуулагчдаа үнэ төлбөргүй даатгалд хамруулж ажилласан, улмаар Ард даатгал ХК-иас Ковид-19 цар тахлын улмаас үүсэх эрсдэлээс хамгаалах хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн.

Энэ дашрамд, дотоодод уг коронавирус илэрч, хөл хорио тогтоосноос хойш даатгалын ихэнх компани утсаар болон фейсбүүк мессенжер буюу чатбот ашиглахаас гадна цахим болон гар утасны аппликейшн ашиглан зөвлөгөө өгөх, даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл болон нөхөн төлбөрийн баримт материалыг хүлээн авах, мөн даатгалын нөхөн төлбөр олгох зэрэг даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагчдад хүргэн, үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгааг дуулгахад таатай байна.

Цаг гаргаж бидэнтэй ярилцсан танд маш их баярлалаа



ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

“БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ”–Д ОРСОН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хороо нь 2021 оны 9 дүгээр сарын 08–ны өдрийн 348 дугаар тогтоолоор “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”–д нэмэлт, өөрчлөлт оруулж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлээ.

Дээрх нэмэлт, өөрчлөлтийн зорилго нь инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, дэмжих, хөгжүүлэх зорилгоор гарааны компаниуд биржийн бус зах зээлийн зохицуулалтын хүрээнд хувьцаагаа олон нийтэд санал болгох, олон нийтээс хөрөнгө босгох боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн болно.

Мөн гарааны компани санхүүжилтийн эх үүсвэр татахдаа одоогийн биржийн бус зах зээлийн бэлэн програм хангамж, хөрөнгө оруулагчдын цогц системийг ашигласнаар хөрөнгө татан төвлөрүүлэх ажиллагаа нь ойлгомжтой, хялбар байхаас гадна цаг хугацаа, өртөг зардлыг хэмнэх зэрэг олон давуу талтай юм.

“Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”–д дараах гол харилцааг зохицуулсан нэмэлт, өөрчлөлтүүд орсон:

- Инновацийн тухай хуулийн 121 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн гарааны компани хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгохтой холбогдсон ерөнхий харилцааг Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.
- Гарааны компанийн биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2–т заасан мэргэжлийн холбоо /цаашид “Холбоо” гэх/–ны баталсан холбогдох журмаар зохицуулна.
- Холбоо нь гарааны компанийн биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох хувьцааны бүртгэлийн үйл ажиллагааг шуурхай, ил тод байдлаар зохион байгуулах үүрэгтэй.
- Холбоо нь гарааны компанийн биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох хувьцааны бүртгэлийн болон гарааны компанийн мэдээллийн ил тод байдалтай холбогдох харилцааг зохицуулсан журмыг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулна.
- Гарааны компани нь хувьцаагаа үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хадгалуулж, хаалттай хувьцаат компани хэлбэртэй болох нөхцөлд биржийн бус зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгоно.
- Хувьцаагаа биржийн бус зах зээлд санал болгож, шаардлагатай хөрөнгө оруулалтаа амжилттай татсан гарааны компанийн

хувьцааг 1 жилийн хугацаанд биржийн бус зах зээлд арилжаалахгүй.


- Гарааны компани нь андеррайтерийн компаниар дамжуулан хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох замаар нийт 500 сая төгрөг хүртэлх мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх бөгөөд гарааны компанийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хугацаанаас хамааруулан тодорхой хугацаанд үе шаттайгаар хувьцаагаа санал болгож болно.
- Гарааны компанитай гэрээ байгуулан хамтран ажиллах андеррайтер нь түүний холбогдох этгээд байж болохгүй.
- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19–т заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдээс гадна үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр дамжуулан шаардлага хангасан Монгол Улсын иргэн, шаардлага хангасан Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн, олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд, хууль тогтоомжоор хориглоогүй бол Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагууд, Төв банк /Монголбанк/, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпорац, Засгийн газрын тусгай сан, Зээлийн батлан даалтын сан, бүх төрлийн даатгалын сан нь гарааны компанийн биржийн бус зах зээлд санал болгон гаргах хувьцааг худалдан авч болно.
- Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмын шаардлага хангасан Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь гарааны компанийн биржийн бус зах зээлд гаргах хувьцааг худалдан авахад дараах шаардлагыг хангасан байх бөгөөд үүнд арилжаанд зуучилсан тухайн этгээдийн брокер хяналт тавина:
 - ◇ Иргэн нь тухайн санхүүгийн жилийн хугацаанд нийт цэвэр хөрөнгийн 10–аас дээшгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг нэг гарааны компанийн биржийн бус зах зээлд гаргах хувьцаанд оруулна.
 - ◇ Хуулийн этгээд нь тухайн санхүүгийн жилийн хугацаанд нийт өөрийн хөрөнгийн 20–оос дээшгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг нэг гарааны компанийн биржийн бус зах зээлд гаргах хувьцаанд оруулна.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ТҮҮНИЙ ӨРТӨГ

Уур амьсгалын өөрчлөлт нь хүлэмжийн хийн ялгаруулалтын улмаас дэлхийн дулаарал төсөөлснөөс хурдтай явагдаж байна. Хүлэмжийн хийн ялгаруулалт авто тээврийн хэрэгсэл болон нүүрсний утаанаас ихээр ялгардаг бол үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, хог хаягдал нь өөр нэгэн эх үүсвэр болдог.

Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөө ган гачиг, усны хомсдол, гал түймэр, далайн түвшин өсөх, үер, туйлын мөс хайлах, биологийн олон төрөл байдлын тоо буурах зэргээр эх дэлхий сүйдэх болсноор эргээд хүн төрөлхтөний амьдралын эрүүл мэнд, хүнс үйлдвэрлэл, аюулгүй байдалд сөрөг нөлөөллийг авчирч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн цөльсийн нэг градусаас 4 градус болоход асар их нөлөө үзүүлж байгаа нь газрын зураг дээрх өнгөний өөрчлөлт хялбархан тайлбарлаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг томоохон алхам хийхгүй л бол одоогийн байдлаар 2050 он гэхэд дэлхийн дулаарал цөльсийн 4 градусаас илүү нэмэгдэх аюултай. Харин усны түвшингээр цэнхэр дэлхийгээс цагаан дэлхийтэй болж хувирах нь байна. Үүний цаана бидний ундаалдаг усны хомсдлын эрсдэл нуугдана.



Дээр дурдсан сөрөг нөлөөллүүдийг бууруулахын тулд дэлхийн дулаарлын түвшинг жилд 2 градусаас бага хэмд хадгалахад хүн бүр, байгууллага бүр, Засгийн газрууд хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэг түвшинд хүргэхэд зориулагдсан ажиллах, амьдрах, үйлдвэрлэх хэв маягт шилжих шаардлагатайг ухамсарлалаа.

Ингэснээр тодорхой хэмжээний шилжилт хийх нь зардал, өртөг, шаардаж байгаа ба богино болон урт хугацаанд уг зардал ямар нөлөөтэйг сонирхон үзэв.

Хүлэмжийн хийн ялгаруулалтыг тэглэх зардал нь богино хугацаанд өртөг өндөртэй ч, урт хугацаанд зардлыг бууруулж, өгөөжөө өгдөг гэсэн дүгнэлт гарчээ. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой технологийн, нийгмийн, бодлогын зардлууд гардаг.

Технологийн зардал: Нар болон салхин сэнсний эрчим хүч үүсгэгчийн өртөг жил бүр буурдаг. Гэхдээ эдийн засагчид 1 тн нүүрсхүчлийн хийг бууруулах өртөг 20 ам.доллар гэж тооцоолсон. Түүнчлэн нүүрсний хүчлийн хийг бууруулах эрчим хүчний эх үүсвэр гаргах технологийн шийдлүүд судлагдсаар байна.

Нийгмийн зардал: Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас дэлхийн дулаарал хөдөө, аж ахуйн салбарт, далайн түвшингээс давсан үер усны аюул, халуун орны байгалийн сүйдэл зэрэг нийгэмд учруулах хохирол

нь ихээхэн хэмжээний зардлыг дагуулдаг.

Бодлогын зардал: Засгийн газрууд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын зардал урт болон богино хугацаанд өндөр байдаг гэж ОУВС-аас тэмдэглэсэн аж.

Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах нь урт хугацаа шаарддаг ч технологийн өөрчлөлт, шинэчлэл уг зорилгын төв нь юм.

Бодлогын тооцоолол

Нүүрсхүчлийн хийг бууруулахад гарах зардал / тн.ам доллар/

Ойжуулалт	1–10
Сэргээгдэх багцын стандарт	0–190
Салхин сэнс	2–260
ХАА-н хүлэмжийн хийн бодлого	50–65
Хөрсний менежемент	57
Малын менежментийн бодлого	71
Хүлэмжийн хийн стандарт	100–2900
Биодизель	150–420

The economics of climate, IMF

Гэсэн хэдий ч дээрх зардлууд нь уур амьсгалын өөрчлөлтийн улмаас үүсэх зардлаас бага байдаг. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах хамгийн зөв арга нь инновацийг дэмжсэн бодлогын бүтээх шийдэл, түүнийг юм.



ФИНТЕК БА РЕГТЕК

ФИНТЕКИЙН ТОП ТРЕНДУУД

ФИНТЕКИЙН ТОП ТРЕНДУУД

Ковид-19 цар тахлын улмаас 2020 онд дэлхийн эдийн засаг уналтад орж ихэнх эдийн засгийн салбаруудад хүндээр нөлөөлж эхэлсэн. Финтекийн салбарын хувьд 2019 онд дэлхий даяар нийт финтекийн хөрөнгө оруулалт 215.4 тэрбум ам.доллар байсан бол 2020 онд 121.5 тэрбум доллар хүрч хөрөнгө оруулалтын хэмжээ ихээр буурсан. Харин 2021 оны эхний хагас жилийн байдлаар дэлхий даяар нийт 98.0 тэрбум ам.долларын финтекийн хөрөнгө оруулалт, мөн 2,456 хэлцэл хийгдсэн нь шинэ амжилт болж байна. Үүнээс 51.4 тэрбум ам.доллар нь Америкийн бүс, 39.1 тэрбум доллар нь EMEA бол Ази, Номхон далайн бүсийн нийт хөрөнгө оруулалт 7.5 тэрбум доллар байна.

Зураг. Финтекийн салбарын хөрөнгө оруулалт



Цар тахлын үеийн нөхцөл байдал нь Финтекийн салбарыг анхаарлын төвд очих боломжийг үүсгэсэн. Дижитал үйлчилгээний хэрэглээ нэмэгдсэн нь Финтекийн хөрөнгө оруулалт нэмэгдэх шалтгаан болсон бөгөөд үүнийг дагаад тус салбарын технологид ихээхэн дэвшил гарах хандлагатай байна. Иймд цаашдын санхүүгийн салбарын чиг хандлагыг танилцуулж байна.

Digital-Only Banks

Зөвхөн дижитал банк нь бүхэлдээ онлайн ажилладаг. Данс нээлгэхээс эхлээд гүйлгээ хийх хүртэлх бүх зүйлийг гар утасны програм эсвэл цахим сайтаар дамжуулан хийдэг. Уламжлалт банкнаас ялгаатай нь



ямар нэгэн салбаргүй, зөвхөн инновацид суурилсан. Үнэн хэрэгтээ уламжлалт банкуудын үйлчилж чаддаггүй үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангах нь эдгээр дижитал банкуудын гол санаа юм. Ковид-19 цар тахлын үеэр хөл хорио тогтоосон нь олон хүмүүсийг онлайн үйлчилгээг сонирхоход хүргэж дижитал банкуудын өсөлтийг хурдасгаад байна.

Энэхүү дижитал банкуудын нэг давуу тал нь онлайн аар дагнан үйл ажиллагаа явуулахад гарах зардал бага учир гүйлгээний шимтгэл багатай, өндөр хүү санал болгож чаддаг. Түүнчлэн ямар нэг салбар луу явах шаардлагагүйгээр хүссэн үедээ хаанаас ч үйлчилгээ авах боломжтой.



FinTech-Bank partnerships

Дижитал банкуудаас хоцрохгүйн тулд уламжлалт банк, санхүүгийн байгууллагууд ч үйлчилгээгээ онлайн аар үзүүлж байна. Олонх байгууллагууд нь дижитал дэд бүтцийг бие даан хөгжүүлэхийн оронд финтекийн гарааны компаниудтай хамтран ажиллаж байна. Финтек компани талаас зах зээлд өөрсдийгөө таниулах, санхүүгийн туршлага хуримтлуулах, мөн томоохон банкууд шаардлагатай мөнгөн урсгалыг бий болгох зэрэг давуу талтай. Харин банкны хувьд технологийн шинэчлэлийг ашиглаж илүү хүртээмжтэй, өргөн хүрээний үйлчилгээг хэрэглэгчдэдээ санал болгох боломжийг олгодог.



Blockchain Decentralized Finance

Төвлөрсөн бус санхүү (DeFi) нь 2010-аад оны эхээр биткойн блокчэйн нэвтрүүлснээс хойш хамгийн их анхаарал татсан сэдэв байсаар ирсэн. Энгийнээр хэлэхэд энэ нь банк, брокер гэх мэт зуучлагчаар дамжихгүйгээр хэн ч санхүүгийн арилжаанд шууд оролцох боломжтой систем юм. Дижитал мөнгөний хувьд төвлөрсөн бус санхүүгийн тодорхой хэрэглээ мөн боловч үүгээр хязгаарлагдахгүй, хувьцааны арилжаа, даатгал зэрэг санхүүгийн бүх салбарт нэвтэрч байна.



Autonomous Finance

Автономит санхүү гэдэг нь хиймэл оюун ухаан (AI)-аар дамжуулан хувь хүнд тохирсон, автоматжуулсан санхүүгийн үйлчилгээг хүргэх явдал юм. "Өөрийгөө жолооддог

мөнгө" гэсэн нэр томьёо нь финтекийн энэ салбарт хамгийн тохиромжтой тодорхойлолт гэж хэлж болно. Товчхондоо тухайн хүний зорилго, эрсдэлийг тэсвэрлэх чадвар, нас, банкны үлдэгдэл болон бусад хүчин зүйлд тулгуурлан санхүүгийн төлөвлөгөөг бие даан үүсгэж, хэрэгжүүлэх боломжийг олгодог. Энэ нь таны мөнгийг 24/7 удирддаг ухаалаг дижитал санхүүгийн зөвлөхтэй адил юм.

Жишээлбэл оны эцэс гэхэд нэг сая доллар хэмнэхийг хүсэж байна гэж бодвол бие даасан санхүүгийн програм нь таны эрсдэлийг хэрхэн тэсвэрлэх чадварыг харж, түүнд тохирсон санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх сонголтыг харуулдаг. Эсвэл таны сарын төсөвт илүүдэл мөнгө олдвол өндөр өгөөжтэй хөрөнгөд тэр хэмжээгээр хөрөнгө оруулалт хийж болно.

Financial inclusion

Дэлхийн банкны тодорхойлсон санхүүгийн хүртээмж гэдэг нь "хэрэгцээгээ хангасан ашигтай, боломжийн санхүүгийн үйлчилгээг авах боломжтой хувь хүмүүс" гэсэн утгатай. Зорилго нь хүн бүр санхүүгийн болон нийгмийн байдлаас үл хамааран хадгаламж, төлбөр, зээл олгох зэрэг банкны чухал үйлчилгээг ашиглах боломжийг бүрдүүлэх юм.

Хөгжиж буй орнуудад банкны үйлчилгээ авах боломжгүй эсвэл банкны үйлчилгээгүй орон нутагт амьдардаг хувь хүмүүс ихээхэн байдаг. Жишээлбэл, Марокко, Вьетнам, Мексик зэрэг орны хүн амын 60 гаруй хувь нь санхүүгийн үйлчилгээний гадна байдаг ба илүү хүртээмжтэй байх шийдлийг эрэлхийлдэг. Энэ нь эргээд эдийн засгийн өсөлтийг бүхэлд нь нэмэгдүүлэх боломжтой.



Mobile wallets

Мобайл хэтэвч нь зээлийн карт, урамшууллын карт, купон зэрэг хэрэглэгчийн төлбөрийн мэдээллийг хадгалах дижитал сан юм. Энэ нь тухайн хүнд онлайнаар эсвэл дэлгүүрт хялбараар төлбөр хийх боломжийг олгодог ба Ковид-19 цар тахлын үед хурдацтай хөгжиж буй чиг хандлага болсон. АНУ-д хийгдсэн судалгаагаар 150 сая хүн хамрагдсанаас 98 сая буюу 66 хувь нь мобайл хэтэвч илүү тохиромжтой гэж үзсэн. Хятад улсад мобайл төлбөр тооцооны систем маш ихээр хөгжсөн байдаг. 2023 он гэхэд дэлхийн гар утсаар төлбөр төлөх үйл ажиллагааны 50 хувийг AliPay, WeChat Pay зэрэг платформууд тэргүүлнэ гэсэн таамаг байна.

Biometric Security Systems

Биометр нь хэрэглэгчдийг баталгаажуулахын тулд нүүр, хурууны хээ зэрэг биеийн шинж чанарыг ашиглахыг хэлдэг. Хамгийн чухал давуу тал нь хүний өвөрмөц өгөгдөлд тулгуурладаг учир аюулгүй байдал талаас биометр хамгаалалтыг давах боломжгүй. Биометр нь аль хэдийн өргөн хүрээнд тархсан бөгөөд хэрэглэгчдийн 82 хувь нь биометр идэвхэжсэн ухаалаг утастай болсон. Энэ нь гүйлгээний баталгаажуулалтыг хурдасгадаг тул контактгүй төлбөр тооцооны хувьд маш чухал. Хэрэглэгчид картаа сугалж эсвэл санхүүгийн мэдээллээ өгөхийн оронд хурууны хээгээ сканнердаж төлбөрөө илгээх боломжтой болсноор илүү хурдан бөгөөд аюулгүй байна. Банк талаас хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахын тулд хэрэглэгчээ таньж мэдэх (Know your customer) гэх мэт баталгаажуулалтын процедурт биометрийн хэрэглээ илүү ихээр нэмэгдэнэ.



Voice commands

Дуут командыг ашиглах нь гүйлгээ болон бусад санхүүгийн платформын үйл ажиллагааг баталгаажуулах, зөвшөөрөхийн тулд хэрэглэгчийн дуу хоолойг ашигладаг биометрийн дэд хэсэг юм. Бусад инновацийн нэгэн адил шинээр гарч ирсэн технологи биш юм. Apple-ийн Siri болон Google-ийн Alexa зэрэг дуут туслахууд хүмүүст танигдсан учир 2024 он гэхэд энэ технологийг ашигладаг хүмүүсийн тоо 8.4 тэрбумд хүрнэ гэсэн тооцоо байна. Зарим байгууллагууд FinTech технологидоо дуут командыг туршиж, ашиглаж байгаа ч тохиолдол байна. Гэсэн хэдий ч Финтект дуут командыг нэвтрүүлэх ажил эхний шатандаа явж байна. Дуу таних технологи нь нүүр, хурууны хээ таних зэрэг шиг аюулгүй байдлын тал дээр бэрхшээлтэй тулгараад байна.

Судлаачийн индэр

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ, ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГЫН СУДАЛГАА

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

Гүйцэтгэсэн: Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн А.Мөнгөнсаран

НЭГ. УДИРТГАЛ

Энэхүү судалгаагаар Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, зохицуулалтад шинээр орсон Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарууд болох Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, Үнэт металл, үнэт чулууны салбарын үйл ажиллагаанд тавигддаг олон улсын стандарт, зарим улс орны тухайн салбарын зохицуулалт, туршлагыг судлах зорилготой юм.

Судалгаанд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын зохицуулалтын Америкийн Нэгдсэн Улс, Шинэ Зеланд Улс, Их Британи Улс, Нэгдсэн Үндэстний Байгууллагын туршлага, зөвлөгөө, үнэт металл, үнэт чулууны салбарын зохицуулалтын Канад Улс, Багамын арлын улс, Сингапур Улс, Америкийн Нэгдсэн Улсын туршлагыг багтаалаа.

ХОЁР. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

Энэхүү бүлэгт олон улс дахь үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарын зохицуулалтын туршлагыг тусгасан.

Америкийн Нэгдсэн Улс /АНУ/:

АНУ-ын үл хөдлөх эд хөрөнгийн салбарыг бүхэлд нь зохицуулдаг хууль нь тухайн улсын муж бүрийн зохицуулалтаас хамааран өөр өөр байдаг. Жишээлбэл, зарим мужид гадаадын иргэн АНУ-д үл хөдлөх хөрөнгө эзэмших эрхгүй байхад зарим мужид тухайн зохицуулалтыг зөвшөөрдөг. Харин үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын зохицуулалтыг нэг байгууллага бүхэлд нь хариуцдаг. АНУ-ын худалдааны холбоо /NAR/ нь тухайн улсад үйл ажиллагаа эрхэлж байгаа үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хянан зохицуулдаг үүрэгтэй юм.

NAR-ийн гишүүнд үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг орон сууц, худалдааны зуучлагч, худалдагч, менежер, үнэлгээчин, зөвлөх болон бусад холбогдох хүмүүс багтана. NAR-д гишүүнчлэлтэй бүхий л байгууллага, холбогдох хүмүүс үйл ажиллагаандаа NAR-аас батлан гаргасан Ёс зүйн кодекс, стандартыг мөрдөн ажиллах шаардлагатай байдаг. Энэхүү Ёс зүйн кодекс, стандартыг жил бүр сайжруулан баталдаг бөгөөд хамгийн сүүлд 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр NAR-ын захирлуудын зөвлөлийн хурлаар шинэчлэн баталсан байна. NAR-ийн гишүүдийг бүгдийг нь REALTORS гэж нэрлэдэг бөгөөд тэдгээр нь ёс зүйн дүрмийн нэг буюу хэд хэдэн зүйлийг зөрчвөл тухайн харилцагч шүүхэд нэхэмжлэл гаргах байдлаар асуудлыг шийдвэрлүүлдэг.

Шинэ Зеланд Улс:

Шинэ Зеландын Үл хөдлөх хөрөнгийн газар /REA/ нь тухайн улсын үл хөдлөх хөрөнгийн салбарыг бүхэлд нь зохицуулдаг бие даасан төрийн агентлаг юм. REA-ийн зорилго нь үл хөдлөх хөрөнгө худалдан авах, борлуулах 2 талын эрх ашгийн сурталчлах, хамгаалах, олон нийтийн итгэлийг дээшлүүлэхэд оршино.

REA нь үл хөдлөх хөрөнгийн салбарт өндөр түвшний үйлчилгээ, мэргэжлийн ур чадварыг сурталчилж, худалдан авагч, худалдагч 2 талыг хамгаалахад тусладаг. Цахим хуудсаараа дамжуулан үл хөдлөх хөрөнгийн салбарын бүхий л оролцогчдод салбарын талаар мэдээлэл өгч ажилладаг. Мөн агентуудад зөвлөгөө, зааварчилгаа өгч, тэдгээрийн зан төлөвтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажилладаг. Түүнчлэн салбарт үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй хувь хүн, хуулийн этгээдүүдэд тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг явуулдаг.

Үл хөдлөх хөрөнгийн агентууд REA-аас баталсан мэргэжлийн стандартыг тодорхойлсон ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа дагаж мөрддөг. Мөн сахилгын шийтгэлээр сүүлийн 3 жилд шийтгүүлсэн агентуудын бүртгэлийг хөтөлж олон нийтэд нээлттэйгээр байршуулдаг.

REA-ийн зүгээс Мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр /CPD/-ийг хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү хөтөлбөр нь мэдлэг бэхжүүлэх, тулгамдсан асуудал, чиг хандлага, хууль тогтоомжийн өөрчлөлт зэргийг ойлгоход тусалдаг. CPD нь тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд өөрсдийн үүрэг, дүрэм, журмыг ойлгоход нь туслах замаар салбарын стандартыг нэмэгдүүлэхэд шууд хувь нэмэр оруулдаг.

Их Британи Улс:

Их Британи Улсад үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчийг тусгай зөвшөөрөлжүүлэх ажиллагааг зохицуулсан хууль эрх зүйн орчин одоогоор байхгүй байна. Гэхдээ бүх үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид 1979 оны Үл хөдлөх хөрөнгийн агентлагийн тухай хуулийн дагуу зохицуулагддаг.

Энэхүү хуулийн дагуу үл хөдлөх хөрөнгийн зуучлагч гэж түрээсийн болон бизнесийн үл хөдлөх хөрөнгийг зарж борлуулж, худалдаж авч буй хүмүүстэй хэлэлцээр хийж, танилцуулга хийж байгаа этгээдийг хэлнэ гэж заасан. Үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын үндсэн зохицуулалт нь дараах хууль, журмаар зохицуулагдана:

- Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдын тухай хууль 1979;
- Хэрэглэгчийг шударга бус худалдаанаас хамгаалах журам 2008.

Их Британи дахь үл хөдлөх хөрөнгийн агентлагийн үйл ажиллагааг зохицуулах үүргийг Повис мужийн зөвлөлөөс гаргадаг Үндэсний худалдааны стандартын үл хөдлөх хөрөнгийн агентлагийн баг хариуцдаг. Энэхүү баг нь Их Британийн аль ч хэсэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа үл хөдлөх хөрөнгийн агентлаг 1979 оны Үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдын тухай хуулийн дагуу гүйцэтгэхэд тохирч байгаа эсэхийг үнэлдэг. Хэрвээ хуулийг зөрчсөн байвал сануулах болон торгох шийтгэл ногдуулдаг.

Хэн нэгэн үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид зохицуулалттай эсэх талаар онлайнар хайх нэг шалтгаан нь тухайн хүн

ямарваа нэгэн зуучлагчтай асуудалд орсон гэсэн үг юм. 2007 оны Хэрэглэгчид, үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид ба хохирлыг барагдуулах тухай хуулийн дагуу бүх зуучлагчид батлагдсан нөхөн төлбөрийн схемийн гишүүн байх ёстой. Үйлчлүүлэгч зуучлагчид гомдол гаргахдаа нөхөн төлбөрийг сэргээх схемийг ашиглаж болдог.

Одоогоор үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг тусгай зөвшөөрөлжүүлэх ажил хийгдээгүй байгаа ба шинээр байгуулагдах зохицуулагч байгууллага нь бүх үл хөдлөх хөрөнгийн зуучлагчдыг тусгай зөвшөөрөлтэй болгох ажлыг хийх юм.

Салбарын ёс зүйн код нь 1979 оны хуульд тодорхой стандарт байдлаар багтсан байдаг. Ёс зүйн стандарт нь үл хөдлөх хөрөнгийн зуучлагчид шударга, мэргэшсэн байх ёстой ба ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой талаар тодотгодог.

Нэгдсэн Үндэстний байгууллага /НҮБ/:

2016 онд НҮБ-аас үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн ирээдүйн замын зураглалыг дараахад үндэслэсэн байх ёстой гэж үзэж зөвлөгөө гаргасан байна. Үүнд:

1. Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн ил тод байдал, засаглал, уян хатан байдлыг бэхжүүлж, тэдгээрээ улс орны алсын хараа, ирээдүйтэй холбох шаардлагатай;
2. Ил тод байдал, засаглал, хямд төсөр байдал нь тухайн улсын өрсөлдөх чадвар, шууд хөрөнгө оруулалтын чадавхад шууд нөлөөлдөг тул түүнийг харгалзан энэхүү салбарыг өрсөлдөх чадварын үүднээс авч үзэх шаардлагатай;
3. Орон сууцны хүртээмжтэй байдал нь засгийн газар бүрийн хот, суурин газрын бодлого, эдийн засгийн стратегийн төвд байх ёстой бөгөөд үүнийг олон оролцогч талуудыг ашиглах замаар хөгжүүлэх шаардлагатай;
4. Үл хөдлөх хөрөнгийн зах зээл, түүний мөчлөгийг тасралтгүй хянах нь хямралаас зайлсхийсэн эдийн засагт өгөөжтэй үйл ажиллагаа бөгөөд илүү хүчтэй гарч ирэх мөчлөгөөс урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

ГУРАВ. ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЭДЛЭЛИЙН САЛБАР

Энэхүү бүлэгт үнэт металл, үнэт эдлэлийн салбарын олон улсын зохицуулалтын байгууллагын туршлагаас дурдана.

Канад Улс:

Үнэт металлын тэмдэгтийн тухай хууль нь үнэт металлын эдлэл (алт, мөнгө, цагаан алт эсвэл палладийгаар хийсэн эдлэл)–ийн нэгдсэн тодорхойлолт, чанарын тэмдэглэгээг бүрэн томъёолж, хэрэглэгчдэд худалдан авалт хийх шийдвэр гаргахад нь туслах зорилготой. Мөн энэхүү хуульд үнэт металлын эдлэлтэй холбоотой хуурамч болон төөрөгдөл гаргахаас сэргийлж, хориглох заалтуудыг тусгадаг.

Түүнчлэн үнэт металлын чанартай холбоотой тэмдэглэгээг тусгай зөвшөөрөлтэй дилерүүд хууль, журамд заасны дагуу хийдэг. Чанарын тэмдэг нь Канадын Оюуны өмчийн газар, Канадын Худалдааны тэмдгийн бүртгэлд бүртгүүлсэн худалдааны тэмдгийн хамт байх ёстой. Мөн энэхүү хуульд зааснаар байцаагчид дараах боломжийг эдэлнэ: дилерийн байранд шаардлагатай бүхий л үед нэвтрэх, үнэт металлын эдлэлийг шалгах, бэлэн байлгахыг шаардах, хууль журмын дагуу тэмдэглээгүй аливаа эдлэлийг хурааж авах зэрэг болно. Дилерүүд хуулиар зөвшөөрөөгүй тэмдэглэгээтэй үнэт металлыг импортлохыг хориглодог ба 500 доллар хүртэл хэмжээний мөнгөн торгууль ногдуулна.

Тухайн улсад үйл ажиллагаа эрхэлж буй үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу тодорхой үүргээ биелүүлэхийн тулд Канадын санхүүгийн гүйлгээ ба тайлангийн үнэлгээний төвд орлогоо мэдээлэх ёстой байдаг. Өөрөөр хэлбэл 1 удаагийн гүйлгээ 10,000 доллараас дээш байвал заавал тус төвд мэдээлэх шаардлагатай. Гэхдээ дараах зорилгоор хийгдсэн 10,000 доллараас дээш гүйлгээг мэдээлэхгүй. Үүнд:

- Үнэт эдлэл үйлдвэрлэх;
- Үнэт чулуу огтлох эсвэл өнгөлөх.
- Уурхайгаас үнэт металл эсвэл үнэт чулуу гаргаж авах;

Тиймээс хэрвээ тухайн хүний бүх худалдан авалт, борлуулалтын 90 ба түүнээс дээш хувь нь дээр дурдсан

үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбоотой бол тухай хүнийг үйлдвэрлэгч гэж тооцох тул орлогоо мэдээлэх шаардлагыг тавихгүй юм.

Багамын арлын улс:

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тухайн улсын 2018 оны Санхүүгийн гүйлгээ тайлагналын хуулиар үүрэг хариуцлага хүлээдэг. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нэг удаагийн 15,000 доллараас дээш хэмжээтэй гүйлгээ хийхэд хэрэглэгчийг таних шалгалт / CDD/–ыг хийх ёстой байдаг. CDD–аар хийх шаардлага нь харилцагчийн нэр, бусад холбогдох мэдээлэл, утасны дугаар, хаяг зэргийг авахыг ойлгоно.

Мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн дагуу арилжаа эрхлэгчид дараах гол үүргүүдийг хүлээдэг. Үүнд:

- Сэжигтэй гүйлгээг Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх;
- Бүх гүйлгээг таних, баталгаажуулах, тайлангаа хадгалах;
- Үйлчлүүлэгчээ таних ажиллагааг хийх;
- Гуравдагч этгээдийг таних ажиллагааг хийх;
- Комплайнсын ажилтан, мөнгө угаах талаар мэдээлэх ажилтанг томилох;
- МУТСТ комплайнсын хөтөлбөрийг боловсруулж, мөрдөж ажиллах;
- МУТС үйл ажиллагаанд өртөх түвшинг тодорхойлохын тулд эрсдэлийн үнэлгээг хийж баримтжуулах;
- Дагаж мөрдөх эрсдэлд суурилсан бодлого, журмыг боловсруулж, мөрдөх;
- Үйлчлүүлэгчдийн хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох;
- Ажилтнуудыг жил бүр МУТСТ сургалтад хамруулах;

Сингапур Улс:

Үнэт металл, үнэт чулууны тухай хуулийн дагуу үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн борлуулагч нь заавал “дилер”–ээр бүртгүүлэх шаардлагатай байдаг. Зохицуулалттай үл ажиллагаанд:

- Аливаа үнэт чулуу, үнэт металл эсвэл үнэт эдлэлийг үйлдвэрлэх;

- Аливаа үнэт чулуу, үнэт металл эсвэл үнэт эдлэлийг импортлох, борлуулах;
- Аливаа үнэт чулуу, үнэт металл эсвэл үнэт эдлэлийг худалдах, худалдахаар санал болгох;
- Дахин борлуулах зорилгоор аливаа үнэт чулуу, үнэт металл эсвэл үнэт эдлэлийг худалдан авах.

2021 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн бүх зохицуулалттай дилерүүд 6 сар тутамд /хагас жил/ тайлангаа гаргах өгөөжөөсөө татвар төлөх ёстой байдаг. Тухайн татварыг тайлант хугацаа дууссанаас 30 хоногийн дотор төлөх шаардлагатай. Жишээлбэл, 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор тайлангаа хүргүүлээд 7 дугаар сарын 30-ны өдрийн дотор татвараа төлөх ёстой гэсэн үг юм.

Америкийн Нэгдсэн Улс:

АНУ-д Үнэт металл, үнэт чулуу, үнэт эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үүргийг хуульчилсан байдаг ба энэхүү үүрэгт дараах багтана.

Арилжаа эрхлэгч гэдэг нь АНУ-д үнэт чулуу, үнэт металл, үнэт эдлэлийн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авах, борлуулах чиглэлээр бизнес эрхэлдэг, тухайн татварын жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхэлсэн этгээдийг хэлнэ. Үүнд:

50,000 ам.доллараас илүү үнэтэй үнэт эдлэлийг борлуулсан;

Бараа бүтээгдэхүүнээс 50,000 ам.доллараас илүү орлого олсон.

Арилжаа эрхлэгчид нь үйл ажиллагаандаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн стандартыг мөрдөж ажиллах ёстой байдаг. Үүнд:

1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг үнэлсэн бодлого, журам, дотоод хяналтыг нэгтгэнэ. Эрсдэлийн үнэлгээнд дараах хүчин зүйлүүдийг харгалзан авч үзнэ:
 - а) Худалдан авч борлуулдаг бүтээгдэхүүний төрөл, түүний ханган нийлүүлэгчид, түгээлтийн сувгууд, газарзүйн байршлууд;
 - б) Гүйлгээний давтамж;

- в) Терроризмыг ивээн тэтгэгч гэж УИХ-аас тогтоосон харьяаллын бүсэд байрлах данс руу төлбөр тооцоо хийх замаар гүйлгээ хийсэн эсэх.

2. Бодлого, журам, дотоод хяналтад гүйлгээг тодорхойлоход туслах стандартыг багтаасан байх ёстой. Гүйлгээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн гэж илэрхийлж болох хүчин зүйлүүд авч үзнэ:

- а) Их хэмжээний бэлэн мөнгө, олон буюу дараалсан мөнгөн гүйлгээ, аялалын чек эсвэл кассны чек ашиглах, гуравдагч этгээдээс төлбөр төлөх зэрэг ердийн бус төлбөрийн арга;
- б) Үйлчлүүлэгч эсвэл ханган нийлүүлэгчдэд холбоо барих мэдээлэл, санхүүгийн лавлагаа, бизнесийн холбоог бүрэн, үнэн зөвөөр өгөх хүсэлгүй байх;
- в) Худалдан авагч, ханган нийлүүлэгчдийн гүйлгээний талаар ердийн бус нууцлал хийхийг оролдсон, жишээлбэл бизнесийн хэвийн бүртгэл хөтлөхгүй байх;
- д) Худалдан авагч, ханган нийлүүлэгчийн ер бусын худалдан авалт, борлуулалт, эсвэл худалдан авагч, ханган нийлүүлэгчийн төрөл;
- е) Үйлдвэрлэлийн стандартад нийцэхгүй худалдан авалт, борлуулалт.

3. Дараах үүрэгтэй Комплайнсын ажилтанг томилсон байна:

- а) Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөр үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх;
- б) Мөнгө угаахтай тэмцэх хөтөлбөрийг эрсдэлийн үнэлгээ, шаардлага, Сангийн яамнаас гаргасан нэмэлт удирдамжаарх өөрчлөлтийг тусгаж шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулна;

ДӨРӨВ. САНАЛ, ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаанд улс орнуудын болон олон улсын байгууллагын зохицуулалтын туршлагаас тусгасан ба бүхий л улс орнууд санхүүгийн бус бизнес, мэргэжлийн

үйлчилгээ үзүүлэгчдийг зохицуулахдаа Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлд баримталдаг стандарт, шаардлагыг хэрэгжүүлж ажилладаг байна.

Түүнчлэн 2007 оны дэлхийн санхүүгийн хямралын үеэр хөндөгдсөн гол асуудлын нэг нь үл хөдлөх эд хөрөнгийн салбарын ёс зүйн хэм хэмжээний асуудал байсан бөгөөд олон улс энэхүү салбарын ёс зүйн хэм хэмжээний байдалд санаа тавьдаг байна. Энэ хүрээнд улс бүрийн зохицуулагч байгууллагаас салбарт нийтээр дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээний журмыг боловсруулан хэрэгжүүлж байна.

Мөн судалгаанд дурдагдсан улс орон бүр салбар бүрийг зохицуулах хуулийг баталсан байгаа ба тухайн хуулийнхаа хүрээнд хавсралтаар салбарт дагаж мөрдөх стандарт, зөвлөгөө, журмыг баталсан байна. Ингэснээр зохицуулалтын байгууллагууд ч салбарт үйл ажиллагаа явуулахдаа төөрөгдөлд орохгүйгээр хуулийн дагуу журмыг боловсруулан ажиллах бүрэн боломжтой байна. Харин Канад Улсад үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчдад тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг эхлүүлээгүй байгаа бол зарим улсад холбооны зохицуулалт дор эрхээ аван үйл ажиллагаа үзүүлж байна.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн хувьд үйл ажиллагааг нь үргэлж мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлд уяж, журам, зааврыг нь тухайн чиглэлд боловсруулан ажилладаг байна. Улс орон бүр тухайн салбарыг зохицуулах зохицуулалтын байгууллагыг тусад нь байгуулан ажиллаж байгаа ба тухайн байгууллагаас зөвшөөрөл авсан арилжаа эрхлэгчид л салбарт үйл ажиллагаа явуулах эрхтэй байна.

Эндээс харахад, манай улсын хувьд зохицуулалтын байгууллага болох Санхүүгийн зохицуулах хорооноос салбар бүрийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх ёс зүйн код, болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх журам, зааврыг жишиг хэлбэрээр боловсруулж тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд хэвшүүлэх шаардлагатай юм.

ТАВ. ЭХ СУРВАЛЖ

<https://www.nar.realtor/>

<https://iclg.com/practice-areas/real-estate-laws-and-regulations/usa>

<https://www.rea.govt.nz/real-estate-professionals/education-and-obligations/supervision/#3349-supervision-standard>

<https://www.propertyroad.co.uk/are-estate-agents-regulated/>

<https://www.weforum.org/agenda/2016/04/how-should-we-regulate-the-real-estate-industry/>

<https://ccb.finance.gov.bs/wp-content/uploads/2020/04/DEALERS-IN-PRECIOUS-METALS-AND-STONES-AND-PAWN.pdf>

<https://acd.mlaw.gov.sg/guidance-materials/>

[https://acd.mlaw.gov.sg/images/Guidelines%20for%20regulated%20dealers_20201214_V2.0Final%20\(Updated\).pdf](https://acd.mlaw.gov.sg/images/Guidelines%20for%20regulated%20dealers_20201214_V2.0Final%20(Updated).pdf)

<https://www.lexology.com/library/detail.aspx?g=a74d3975-1214-4ca8-b729-5f2b569863ba>

<https://www.ecfr.gov/cgi-bin/text-idx?>

[SID=cdfa172c14a40777eeae06a506c48ec4&mc=true&node=pt31.3.1027&rgn=div5#_top](https://www.ecfr.gov/cgi-bin/text-idx?SID=cdfa172c14a40777eeae06a506c48ec4&mc=true&node=pt31.3.1027&rgn=div5#_top)



САНХҮҮГИЙН ЛУЙВАР ГЭЖ ЮУ ВЭ?

Санхүүгийн луйвар гэдэг нь: банк, санхүүгийн байгууллагын цахим сүлжээнд хууль бусаар нэвтрэх, хуурамч болон төөрөгдүүлсэн мэдээлэл ашиглан гайхалтай үр дүн амлах замаар бусдын эд хөрөнгийг завших үзэгдлийг хэлнэ.

СҮҮЛИЙН ҮЕД ДЭЛГЭРЧ БУЙ ЛУЙВРЫН ТӨРЛҮҮД



Хөрөнгө оруулалтын луйвар

01

Техник технологи эрчимтэй хөгжиж, хүн болгон хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон цаг үед тус луйврын хохирогчдын тоо нэмэгдсээр байна.

Төрийн зохицуулалтгүй, урьдчилгаа төлбөр төлөхийг шаарддаг, хуурамч мэдээлэл ашиглан бусдаас хөрөнгө оруулалт татаж буй луйврын эрсдэлээс урьдчилан сэргийлээрэй.



Үл хөдлөх хөрөнгийн луйвар

Үл хөдлөх хөрөнгийн үнийн хэлбэлзэл ихээр нэмэгдэж байгаатай холбогдуулан луйврын тохиолдол өссөөр байна.

Хуурамчаар бичиг баримт үйлдэн өөрийн эзэмшлийн бус бусдын хөрөнгийг түрээслэх, дамлан худалдаалах, барьцаалан зээл авах гэх мэт луйврын эрсдэлээс урьдчилан сэргийлээрэй.



Албан ёсны зөвшөөрөлтэй зуучлагчаар дамжуулах



Худалдан авалтын болон түрээсийн гэрээгээ судлах



Барилгын компания судлах

02

“Санхүүгийн луйврын нийтлэг төрлүүд, тэдгээрийн шинж”-ийн талаар
ӨМНӨХ ЗУРАГТ ХУУДАСНААС мэдээлэл аваарай.



САНХҮҮГИЙН ЛУЙВРААС ХЭРХЭН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВЭ?

01

Хувийн мэдээллээ
задруулахгүй байх

- Карт
- Интернет банк
- Бүх төрлийн
нууц үг



02

Богино хугацааны
сэтгэл хөдлөлд
автахгүй байх



03

Эргэлзээтэй
санагдвал татгалзах

Мэргэжлийн хүнээс
зөвлөгөө авах



04

Маш сайн
судалгаа хийх



05

Урьдчилж төлбөр
төлөхгүй байх



**Санхүүгийн луйврын гэмт хэргийн талаар дараах
байгууллагуудад мэдэгдэж болно.**



- Цагдаагийн ерөнхий газар
- Эрүүгийн цагдаагийн алба
- Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

Хэрэв та санхүүгийн луйврын хохирогч болсон тохиолдолд оршин суугаа нутаг дэвсгэрийн харьяа шүүхэд өргөдөл гаргахыг зөвлөж байна.



ХЭРЭГЛЭГЧ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ЦАР ТАХЛЫН ҮЕД ЗОХИЦУУЛАЛТЫН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖЛУУД

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар албан бичгээр нийт 275 өргөдөл, гомдол албан бичгээр ирүүлснийг хүлээн авч 257 өргөдлийн шийдвэрлэсэн, 18 өргөдөл хянагдаж, цахимаар 174 өргөдөл гомдол ирүүлсэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад тулгарч буй хүндрэл бэрхшээл:

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад тулгарч буй хүндрэл бэрхшээл:

Хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах үр дүнтэй тогтолцоо бүрдээгүй, нөгөө талаас олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжих шатандаа байгаа, санхүүгийн мэдлэг дутмагаас өөрсдийн эрх ашгийг хэрхэн хамгаалах тухай ойлголт иргэдийн дунд хангалтгүй байгаа нь бэрхшээлийг үүсгэж байна.

Мөн өргөдөл шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд нь тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна нэмэлт материал

шаардах зэргээс шалтгаалж хугацаа хэтрэх тохиолдол гарч байдаг.

Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Санхүүгийн хэрэглэгчийн /Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн/ эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавьж, санхүүгийн суурь боловсрол, дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн ил тод, шударга зах зээлийг хөгжүүлэх, иргэдийн санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг сайжруулах:

- 1: Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах хяналт, зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- 2: Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалахад зах зээлд оролцогчдын оролцоог нэмэгдүүлнэ.
- 3: Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлнэ.



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ЗАСАГЛАЛЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГТ ЗАЙЛШГҮЙ АНХААРАЛ ХАНДУУЛАХ

(ESG) ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН АСУУДЛУУДАД АНХААРАХ НЬ

Уур амьсгалын өөрчлөлт болон хүрээлэн буй орчны (E–environment) асуудлуудад тогтмол анхаарал хандуулж байгаа боловч зарим талаараа цар тахлын нөлөөллөөс үүдэлтэй нийгмийн (S–social) хүчин зүйлүүд дээр илүүтэйгээрх анхаарал хандуулж, ESG асуудлууд нь аж ахуйн нэгжүүд, зохицуулагчид болон хөрөнгө оруулагчдын хэлэлцэх асуудлын жагсаалтад орсоор байна.

Ихэнх ТУЗ-үүд олон нийтийн төсөөлж байснаас илүү сайн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх, ажиллахад тохиромжтой газар байхыг хүсэх зэрэг зорилго болон оролцогч талууддаа илүү анхаардаг. Олон жилийн турш бизнесийн удирдагчид урт хугацааны амжилтыг бий болгохын зэрэгцээ ур чадвар, хүчирхэг соёлыг хөгжүүлэх, нийгэмд хүндэтгэлтэй хандах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бий болгоход анхаарч ирсэн. Түүхэнд ийм асуудал санхүүгийн үнэ цэнийг сулруулдаг гэж үздэг байсан ч тогтвортой бизнесийн үйл ажиллагаа нь эрсдэлийн менежментийн үүднээс чухал ач холбогдолтой төдийгүй ихэвчлэн үнэ цэнийг нэмэгдүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь улам бүр нэмэгдсээр байна.

ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ, ЧИГЛЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

Сүүлийн 12 сарын хугацаанд ТУЗ-ийн түвшинд ESG-д анхаарлаа хандуулах тэргүүлэх чиглэл дахин өөрчлөгдсөн. Үүнд хөрөнгө оруулагчдын үзэл бодол, ESG-д нийцсэн хөрөнгө оруулалтад хандах хандлага ихээхэн өөрчлөгдсөнтэй холбоотой бөгөөд хөрөнгийн эзэмшигчид болон хөрөнгийн менежерүүд НҮБ-ын хариуцлагатай хөрөнгө оруулалтын зарчмууд, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд зэрэг дэлхийн санаачилгад улам бүр тууштай хандаж байна.

Компаниуд болон тэдгээрийн төлөөлөн удирдах зөвлөлүүд одоо ESG-тэй холбоотой санхүүгийн бус тайлагналын өсөн нэмэгдэж буй шаардлагуудыг дагаж мөрдөх шаардлагатай болж байна. Эдгээрийн заримыг нь салбарын байгууллагууд болон сайн дурын дүрмээр тогтоодог эсвэл эдгээр шаардлагуудын ихэнх нь хуулиар тогтоогдож байгаа ч энэ хандлага цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. 2021 оны Их-7-ийн дээд хэмжээний уулзалтын дараа нийтлэгдсэн мэдэгдэлд зах зээлд оролцогчдод тууштай, шийдвэр гаргахад тустай мэдээллээр хангадаг, уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсэгт үндэслэсэн уур амьсгалтай холбоотой санхүүгийн мэдээллийг заавал оруулах чиглэлд шилжихийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн нь анхаарал татаж байв.

ИЛ ТОД БАЙДАЛ

Европоос гарч буй ESG-тэй холбоотой зохицуулалтын давлагаанаас гарч буй сэдвүүдийн нэг нь хөрөнгө эзэмшигчид

болон хөрөнгийн менежерүүд өөрсдийн ESG-ийн итгэмжлэл, санхүүгийн бүтээгдэхүүн, багцын талаарх мэдээлэл, ESG хүчин зүйлд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэх явдал юм. Ялангуяа ногоон хөрөнгө оруулалтын зах зээл дээр жишиг үнэлгээ, нийтлэг стандарт байхгүй байгааг даван туулах хэрэгцээ шаардлагаас үүдэн ЕХ-ны Таксономын журам (мөн түүнийг дагалдах бусад стандартууд) нь хөрөнгө эзэмшигчид болон жижиг хөрөнгө оруулагчдад багцын компаниуд болон сан/хөрөнгийн менежерүүдийн хооронд ижил төстэй харьцуулалт хийх боломжийг олгох "нийтлэг хэл" бий болгоход чиглэсэн хамгийн амбицтай бөгөөд нарийвчилсан оролдлого байж магадгүй юм. Хөрөнгө оруулагчдад өөрсдийн ESG-г ил болгох үүргээ биелүүлэх боломжийг олгох ESG-ийн тодруулгыг өгөхөд компаниудад илүү их дарамт ирэх тул энэхүү хөгжил нь цаашдын компанийн тайланд чухал нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Хөрөнгө эзэмшигчид болон хөрөнгийн менежерүүд ихэвчлэн өөрсдийн хөрөнгө оруулалттай компаниудтай хамтран ажиллах, дээд удирдлагатай уулзалт хийх, саналын эрхээ хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт эсвэл хөрөнгөө гаргах шийдвэр гаргах зэргээр бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөхийг эрмэлздэг. Байгууллагын болон жижиг хөрөнгө оруулагчдын аль аль нь компанийн болон үнэт цаасны хуулийн механизмыг ашиглан компанийн зан төлөвт нөлөөлөхийг эрэлхийлж, компаниудаас ESG-тэй холбоотой тодорхой саналууд, ялангуяа уур амьсгалтай холбоотой саналуудыг жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураалтад оруулахыг шаардаж байна. Эдгээр саналуудын ихэнхийг сонирхлын бүлгүүд эсвэл жижиг хувьцаа эзэмшигчид өдөөж, дэмжсэн ч удирдах үүрэг хариуцлага улам бүр нэмэгдүүлснээр институцийн хувьцаа эзэмшигчид ийм санаачилгыг дэмжих хүсэл эрмэлзэл нэмэгдсээр байна.

ШИЙДВЭРҮҮД

Шинээр гарч ирж буй өөр нэг чиг хандлага бол аж ахуйн нэгжүүд өөрсдийн уур амьсгалын үйл ажиллагаа эсвэл уур амьсгалын шилжилтийн төлөвлөгөөндөө сайн дурын үндсэн дээр хувьцаа эзэмшигчдээс санал авахыг хүсэж, "уур амьсгалын талаар" шийдвэрүүдийг санал болгох явдал юм. Олон хөрөнгө оруулагчид ийм шийдвэрийг дэмжиж байгаа хэдий ч хөрөнгө оруулагчдын дунд энэ нь компанийн стратеги эсвэл урт хугацааны төлөвлөгөөтэй холбоотой хэд хэдэн сорилтыг дагуулдаг гэж үздэг хүмүүс байдаг.

Эдгээр бүх шинэчлэлт, хөгжүүлэлтийг нэгтгэснээр компаниуд болон хөрөнгө оруулагчдад ESG-ийн талаар тодорхой байр суурь, шийдвэр гаргах үйл явцад ямар үүрэг гүйцэтгэх талаар тодорхой байр сууриа илэрхийлэх боломжийг олгох юм.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


||| САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО ... 2021. III




ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ






ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ




ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ






БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА





ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГА БОЛОН ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ



Брокер 248

Агент 1,272



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД

Давхардсан тоогоор 2021 оны 3 дугаар улирлын байдлаар ҮХЭХЗ-ын байгууллага нийт **4590 хэлцлээр**, 759.22 мянган м.кв талбай, **613.95 тэрбум төгрөгийн** үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг **зуучлан худалдан, шилжүүлжээ.**

Тайлант хугацаанд нийт **1511 хэлцлээр** 125.16 мянган м.кв талбай, **13.33 тэрбум төгрөгийн** үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг **зуучлан хөлслүүлж, түрээслүүлжээ.**

ҮНЭТ МЕТАЛЛЫН ХУДАЛДАН АВАЛТ /ТӨГРӨГ/

464.1 тэрбум төгрөг

ҮНЭТ МЕТАЛЛЫН БОРЛУУЛАЛТ /ТӨГРӨГ/

404.2 тэрбум төгрөг



ҮХХЗБ
227



ҮМҮЧТХЭАЭ хуулийн этгээд
39



ҮМҮЧТХЭАЭ иргэд
65



ҮМҮЧ-ны арилжаа эрхлэгч иргэд
125




ҮМҮЧ-аар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд
235

ӨРГӨН ДУРАН

САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙН НИЙГЭМЛЭГИЙН ЗҮҮН ЕВРОП, ТӨВ АЗИЙН БҮСИЙН САНААЧИЛГЫН 8 ДАХЬ УДААГИЙН ХУРАЛ БОЛЛОО

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн Зүүн Европ, Төв Азийн бүсийн санаачилга /ECAPI/-ын наймдугаар хурал боллоо.


Санхүүгийн зохицуулах хороо нь Европ, Төв Азийн бүсийн санаачилгын долдугаар хурлаар бүсийн санаачилгын даргаар сонгогдсон бөгөөд энэ удаагийн хурлыг Санхүүгийн зохицуулах хорооны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатар нээж хэлсэн үгэндээ “Зүүн Европ, Төв Азид санхүүгийн хүртээмжийг сайжруулах чиглэлд гишүүн байгууллагууд өнгөрсөн хугацаанд үр дүнтэй хамтран ажиллаж, хүчин чармайлт гаргасанд чин сэтгэлээсээ талархал илэрхийлэе. ECAPI бол бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, сайн туршлага солилцох, тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэх өргөн боломжийг олгодог хамтын ажиллагааны платформ юм. Иймд гишүүн байгууллагууддаа цаашид ч бүс нутгийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн төлөө нэгдсэн зорилго, зүтгэлтэй нэгдэж



ажиллахыг уриалж байна” гэдгийг онцоллоо.

Хурлаар өмнө хэрэгжүүлсэн ажлууд, түүний үр дүн, ололт амжилтыг дүгнэж ирэх онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэлэлцлээ. Тухайлбал, 2021 онд бүсийн санаачилгын гишүүн байгууллагууд хамтран “Хил дамнасан мөнгөн гуйвуулгын систем”, “Хүүхэд, залуучуудад зориулсан санхүүгийн чадамжийн матриц”, “Үйлчлүүлэгчээ мэдэх үндсэн зарчим” зэрэг гарын авлага, бодлогын баримт бичгүүдийг боловсруулан гаргасан. Ингэснээр гишүүн улсуудад дээрх чиглэлүүдээр харилцан мэдээлэл, туршлага солилцох боломж бүрдсэнээс гадна бүс нутаг дахь хамтын ажиллагааг дэмжих, гишүүн улсуудад тулгамдсан нийтлэг асуудлыг олж тогтоох, цаашлаад шийдвэрлэхэд түлхэц болсон юм.

Санаачилгын гишүүн байгууллагууд 2022 онд “Гомдол барагдуулах механизм”, “Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн боловсрол” зэрэг асуудалд анхаарч, хамтарч ажиллахаар тохиролцож, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав. Мөн хурлын дараа Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгийн Европ дахь төлөөлөгчийн газраас гишүүн байгууллагууд, тэр дундаа ажлын хэсгийн гишүүдэд зориулсан “Нээлттэй санхүүжилтийн дэд бүтэц цахим сургалт”-ыг зохион байгуулсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох албан хаагчид сургалтад амжилттай хамрагдлаа. Сургалтын зорилго нь гишүүн байгууллагуудын албан хаагчдыг хил дамнасан төлбөрийн систем, мэдээлэл солилцох техникийн болон засаглалын стандартуудын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх юм. Түүнчлэн, сургалтад оролцогчид мэдээллийн нууцлал, хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах, хэрэглэгчийн



хариуцлага, гомдлыг барагдуулах олон улсын сайн туршлагатай танилцах, харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлж өгснөөрөө онцлогтой.

Бүсийн санаачилгын бүрэлдэхүүнд Санхүүгийн зохицуулах хороо, Казахстаны Санхүүгийн зах зээлийг зохицуулах, хөгжүүлэх агентлаг, Армени, ОХУ, Узбекистан, Беларус, Тажикстаны төв банк багтдаг бөгөөд наймдугаар хуралд гишүүн байгууллагуудын 60 гаруй төлөөлөл оролцлоо.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Шатахууны хомсдол бий болж, дундаж үнэ нэмэгдсээр байна.

Оросын Холбооны Улсын Санкт-Петербургийн бараа, түүхий эдийн бирж дээр "Премиум-95" бензиний ханш Европын индексээр 0.3 хувиар өсөж, 1 тонн 60,380 рубль болж, хоёр өдөр дараалан түүхэн дээд үнэд хүрчээ. "Премиум-95" бензиний үнэ есдүгээр сарын 15-наас дахин нэмэгдэж эхэлж, 3.5 хувиар өссөн байна. Бусад шатахууны үнэ мөн адил өсөж байгаа бөгөөд нэг өдрийн дотор АИ-92 бензиний үнэ 0.7 хувиар, дизель түлш 0.3 хувиар тус тус нэмэгдсэн байна. ОХУ-ын Эрчим хүчний яамнаас мэдээлснээр, "Оросын шатахууны зах зээл тогтвортой байгаа бөгөөд газрын тосны үйлдвэрүүдийн засварын ажил, зуны түлшнээс өвлийн түлш рүү шилжсэнтэй холбоотойгоор ханшийн хэлбэлзэл үүссэн байна. Үйлдвэрүүдийн төлөвлөгөөт засварын ажлууд дууссаны дараа бензиний үйлдвэрлэл нэмэгдэж, ханшийн хэлбэлзэл тогтворжино" гэж мэдээлсэн.

Их Британи Улсад жолооч нар шатахуун нөөцөлснөөс шалтгаалан шатахуун түгээх станцуудын тэн хагас орчмын нөөц дуусаад байгаатай холбогдуулан Ерөнхий сайд Борис Жонсон олон зуун цэргийг дайчлахаар төлөвлөж байна. Иргэд шатахуун их хэмжээгээр нөөцөлсний улмаас дундаж үнэ хэвийн түвшнээс 180 хувиар өссөн.

Киргиз Улсад шатахууны дундаж үнэ ОХУ-ын зах зээлийнхээс өндөр байгаа талаар тус улсын Өрсөлдөөний бодлого зохицуулалтын газар мэдээлжээ. Хэрэв бензин болон дизель түлшний экспортын үнэ дотоодын зах зээлийн үнээс өндөр байвал энэ зөрүүг төр үйлдвэрлэгчдэд нөхөн төлнө. Харин эсрэг тохиолдолд нефтийн компаниуд төсөвт зөрүүг нь төлдөг. Энэ нь дотоодын зах зээлд үнийг тогтвортой байлгахад тусалж байгааг шинжээчид онцолж байна" гэж Киргизийн хяналт зохицуулалтын газар мэдээлжээ.

Казахстан Улсын өмнөд хэсэгт орших Туркестан муж, Шымкент хотод шатахуун түгээх 400 гаруй жижиг станц хаагдах гэж байгааг "Atameken Business News" телевиз мэдээлжээ. Шатахуун түгээх станцуудад зарах түлш огт байхгүй гэдгийг тус телевиз онцолсон байна. Хувийн сүлжээнээс гадуурх шатахуун түгээх станцуудын 80 орчим хувь нь хоосон байгаа нь сүүлийн хоёр сард байдал улам дорджээ. Байдал дордсоны нэг шалтгаан нь Атыраускийн газрын тос боловсруулах үйлдвэрт үүссэн хүндрэлтэй холбоотой байна.

Дэлхийн банк "Doing Business" тайлангаа гаргахаа болино.

Дэлхийн банкны удирдлагууд улс орнуудын бизнесийн орчны талаарх "Doing Business" /"Бизнес эрхлэхүй"/ тайланг гаргахаа болих шийдвэр гаргажээ. Цаашид бизнес, хөрөнгө оруулалтын

орчныг үнэлэх шинэ арга барилаар ажиллахаар болсноо мэдэгдсэн байна.

БНХАУ-ын ДНБ-ний өсөлтийг 3 дугаар улиралд 0 хувь байна гэж таамаглаж байжээ.

"БНХАУ-ын эдийн засаг цар тахлын улмаас 2021 оны 3 дугаар улиралд ихээхэн удаашрах төлөвтэй байна. БНХАУ-ын эдийн засаг нь өнгөрсөн улирлаас 0.3 хувиар өснө" гэж "Market Securities" ХХК-ийн ахлах эдийн засагч К.Барро таамаглажээ. Энэ таамаглал нь "Bloomberg"-ийн эдийн засагчдын хийсэн судалгааны дундаж тооцооллоос 1.1 хувиар доогуур байна. 2021 оны 3 дугаар улирлын ДНБ-ий өсөлтийн мэдээлэл гарах хараахан болоогүй байгаа ба 1-2 дугаар улирлын ДНБ-ий өсөлт 1.3 хувь байжээ.

БНХАУ-д 2022 оны 2 дугаар сард болох Өвлийн Олимпын наадмын өмнө тус улс халдварыг тогтоох хязгаарлалтын хатуу арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа тул үүсэж болох эрсдэлүүд буурч байна гэж үзжээ.

ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийн урьдчилсан таамаглалыг бууруулах төлөвтэй байна.

Олон улсын валютын сан /ОУВС/ энэ онд дэлхийн эдийн засгийн өсөлт 6 хувьтай байна хэмээн долоодугаар сард урьдчилан таамаглаж байсан бол өр, инфляц, эдийн засгийн ялгаатай байдлыг харгалзан үл ялиг бууруулах төлөвтэй байгааг тус сангийн тэргүүн Кристалина Георгиева мэдээлэв. Түүний хэлснээр, дэлхийн эдийн засаг эргэн сэргэж байгаа боловч олон орон "COVID-19"-ийн хангалттай вакцин татан авч чадаагүй байгаатай холбоотойгоор цар тахлын үр дагавар үргэлжилсээр байх төлөвтэй байгаа нь эдийн засгийн сэргэлтэд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл болоод байна.

"Ирэх долоо хоногт танилцуулах Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөвийн шинэчилсэн тайланд хөгжингүй орнуудын эдийн засаг цар тахлын өмнөх түвшиндээ 2022 онд эргэн очно гэж таамаглаж байгаа ч хөгжиж буй дийлэнх орнуудын хувьд эдийн засаг нь сэргэхэд "илүү олон жилийн хугацаа" шаардагдах төлөвтэй байна" гэж К.Георгиева Италийн "Восconi" дурдсан байна. АНУ, БНХАУ эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүрүүд хэвээр байгаагийн зэрэгцээ Итали, Европын эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч байгаа ч дэлхийн бусад хэсэгт нөхцөл байдал хүнд байсаар байгааг онцолжээ.

Европын эрчим хүчний хямрал дэлхий дахинд нөлөөлөх төлөвтэй байна.

Дэлхийн улс орнууд нүүрс хэрэглэхээс татгалзаж, илүү цэвэр эрчим хүчний хэрэглээгээ өсгөн нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор цахилгаан эрчим хүч, орон байрны халаалтад байгалийн хийг түлхүү хэрэглэж байна. Гэвч цар тахлын дараах эдийн засгийн сэргэлтийг дэмжих, хийн шавхагдаад буй хадгалах байгууламжуудыг өвлийн хүйтэн саруудаас өмнө дүүргэхэд хүрэлцэх хэмжээний хангалттай нөөц байхгүй байна. Экспортлогч орнууд улсынхаа хийн нөөцийг хадгалах арга хэмжээнүүд авч байгаатай зэрэгцэн бусад улс орнуудад хүрэлцэхгүй байгаа бөгөөд, хэрэв цаг агаар хүйтэрвэл нөхцөл байдал улам л хүндрэх талаар мэдээлсэн байна.

Европын Засгийн газрууд эрчим хүчний хомсдолын улмаас цахилгаан хангамж тасарч, аж үйлдвэрүүдийг зогсоохоос өөр аргагүйд хүрч болзошгүйг сэрэмжлүүлж байгаагаас үзэхэд тус тивийн хямрал дэлхийн бусад улс орнуудад ч хүндрэл учруулж болзошгүй байна. Европын хий хадгалах байгууламжууд дахь нөөц оны энэ үед түүхэн доод үзүүлэлтэд хүрсэн.

БНСУ-ын үйлдвэрлэгчийн үнийн индекс өсжээ.

БНСУ-ын ханган нийлүүлэгчдийн дунд бараа, үйлчилгээний үйлдвэрлэгчийн үнийн индекс арван сарын турш тасралтгүй өссөн хэвээр байгаа нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотой гэж тус улсын Төв банкнаас /BOK/ танилцуулсан. Үйлдвэрлэгчийн үнийн индекс /PPI/ наймдугаар сард 110.72 байсан нь өмнөх сараас 0.4 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн үнэ өнгөрсөн сараас 2.1 хувиар, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн үнэ 1.0 хувиар, ханган нийлүүлэгчдийн дунд бараа, үйлчилгээний үнэ 0.3 хувиар, үйлдвэрийн бүтээгдэхүүний үнэ 4.0 хувиар, үйлчилгээний салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс тус тус 3.0 хувиар өсжээ.

АНУ-ын Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ хэвээр үлдээжээ.

АНУ-ын Төв банкны үүргийг гүйцэтгэдэг Холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ 0–0.25 хувьд хэвээр үлдээжээ. Хөдөлмөрийн зах зээлийн байдал сайжирч, инфляц 2 хувьд хүрч өсөх хүртэл энэ түвшинг хэвээр хадгалах нь оновчтой гэж үзэж байна” гэж Холбооны нөөцийн сангийн удирдлагуудын хурлын дараа гаргасан мэдээлэлд дурджээ.

Холбооны нөөцийн сан сар бүр хамгийн багадаа 80 тэрбум доллароор төрийн сангийн бонд, хамгийн багадаа 40 тэрбум доллароор моргежийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг

(MBS) үргэлжлүүлэн худалдан авахаар төлөвлөж байна. Гэхдээ эдийн засаг хүлээгдэж байсны дагуу бүхэлдээ сэргэвэл үнэт цаасны худалдан авалтын хурдцыг сааруулах хэрэгтэй болж магадгүй гэж үзэж байна.

Есдүгээр сарын хурлаараа АНУ-ын ДНБ-ий өсөлтийн талаарх таамгийг 7.0 хувиас 5.9 хувь болгож бууруулсан байна. Үүний зэрэгцээ 2022, 2023 оны Америкийн эдийн засгийн өсөлтийн урьдчилсан таамгийг 3.3 хувиас 3.8 хувь, 2.4 хувиас 2.5 хувь болгож тус тус өсгөжээ. Мөн энэ оны инфляцын талаарх таамгийг 3.4 хувиас 4.2 хувь, 2022 оны 2.1 хувийг 2.2 хувь хүртэл өсгөсөн бол 2022 оны ажилгүйдлийн түвшний талаарх урьдчилсан таамгийг 4.5 хувиас 4.8 болгож өөрчилсөн.

Венесуэл улс үндэсний мөнгөн дэвсгэртээсээ зургаан тэгийг хаслаа.

Эдийн засгийн гүн хямрал, хэт инфляцад нэрвэгдсэн Венесуэл Улсын засгийн газар 2021 оны 10 дугаар сарын 1-ны өдрөөс эхлэн мөнгөн дэвсгэртээсээ зургаан тэг хасахаар болжээ.

2008 онд тус улсын ерөнхийлөгч агсан Уго Чавез үндэсний валют боливарын дэвсгэртээс гурван тэг хасах шийдвэр гаргаж байв. Дараа нь 2018 онд түүний залгамжлагч Николас Мадуро дахин таван тэг хасаж байжээ. Энэ бүгд нийлээд сүүлийн 13 жилийн дотор 14 тэг хасаж байна.

Төлбөр тооцоог энгийн, хялбар болгох зорилготой гэх энэхүү шийдвэрийн дараа нэг сая боливарын дэвсгэрт 1 боливартай тэнцүү буюу ойролцоогоор \$0.25-тай тэнцэж байгаа юм. Венесуэлийн жилийн төсөв 2007 онд 115 тэрбум боливар буюу \$50 тэрбумтай тэнцдэг байжээ. Харин өнөөдрийн ханшаар тооцвол энэ нь маш бага мөнгө болох юм. 2020 онд тус улсын инфляц 3,000 хувьд хүрсэн бол өмнөх онд нь 9,500 хүрч байжээ. 2021 онд 1,600 хувьд хүрэх төлөвтэй байгааг Ecosanalitica байгууллага тооцоолсон байна.

Энэ оны тавдугаар сард эрх баригчид сарын цалингийн доод хэмжээг гурав дахин өсгөсөн ч энэ нь нэг килограмм мах худалдаж авахад хүрэхгүй хэмжээнд байгаа бөгөөд Венесуэл улсын дөрвөн иргэн тутмын гурав нь нэн ядуу түвшинд амьдарч байна.




ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 10 дугаар сарын 29-ны өдөр

S&P 500 /^GSPC/


4,551.68 +8.96 (+0.19%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


28,820.09 +759.39 (+2.61%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


7,253.30 +31.29 (+0.43%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

NASDAQ Composite (^IXIC)


15,527.69 +32.60 (+0.21%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com


 Засгийн IV байр , Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,

Улаанбаатар хот, Монгол Улс 15160

 +976-51-264444

 press@frc.mn

 www.frc.mn

 Санхүүгийн зохицуулах хороо

 @FRC_of_Mongolia